

**ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД
ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА
ХҮЛЭЭЛГЭХЭД
ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ**

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН



ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД
ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХЭД
ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ
БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны багийн ахлагч:

Б.Одонгэрэл (Ph.D)

Судлаачид:

Ц.Оч, шүүгч

Ц.Мөнхбат (Ph.D), прокурор

Улаанбаатар хот

2021 он

ННА 67.408
ДАА 345
О-197



ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны багийн ахлагч: Б.Одонгэрэл (Ph.D)

Судлаачид: Ц.Оч, шүүгч

Ц.Мөнхбат (Ph.D), прокурор

Тус тайлангийн үр дүн, санал зөвлөмж нь судлаачдын дүгнэлт бөгөөд
Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN: 978-9919-9812-7-3

© Нээлттэй Нийгэм Форум, 2021

Хаяг: Жамьян гүний гудамж

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240

Утас: 976-76113207

Вэб: <http://www.forum.mn>

И-мэйл: osf@forum.mn

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсад өрнөж буй Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд анх удаа хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх болсон билээ. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ адилтгалын загвараар буюу зөвхөн удирдах түвшний ажилтны хийсэн үйлдэлд хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээхээр зохицуулсан. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш дөрвөн жил гаруй хугацаа өнгөрч байгаа ч хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тохиолдол цөөн байна.

Тиймээс эрүүгийн хариуцлага хүлээх шинэ субъектийн асуудлаар гүнзгийрүүлэн судлах нь зүйтэй хэмээн үзэж судлаач Б.Одонгэрэл, Ц.Оч, Ц.Мөнхбат нарын хийсэн “Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд тулгамдаж буй асуудал” сэдэвт судалгааг олон нийтэд хүргэж байна. Энэхүү судалгаагаар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх онолын чиг хандлага, эрх зүйн зохицуулалт, ижил төстэй орны туршлага, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэсэн өнөөгийн байдал зэргийг судалж дүгнэсний зэрэгцээ цаашид боловсронгуй болгох чиглэлээр тодорхой зөвлөмж санал болголоо.

Нээлттэй Нийгэм Форум нь манай улсад өрнөж буй эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг бодлогын судалгаа, мониторингоор дэмжихийг зорьж ирсэн бөгөөд эдүгээ 30 орчим судалгаа олны хүртээл болоод байна. Мөн бид дээрх судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулах, бодлого шийдвэрт тусгуулах зорилгоор цуврал хэлэлцүүлэг эхлүүлээд байгаа ба хэлэлцүүлгийн видео бичлэгийг манай байгууллагын цахим хуудас, нийгмийн сүлжээнээс олж үзэх боломжтойг дуулгахад таатай байна.

ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГ	6
Нэг. УДИРТГАЛ	7
1.1. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх онолын чиг хандлага	7
1.2. Судалгааны хамрах хүрээ, арга зүй	17
Хоёр. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	20
2.1. Монгол Улсын Эрүүгийн хуулийн эрх зүйн зохицуулалт, түүний онцлог	20
2.1.1. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл	22
2.1.2. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн этгээдийн төрөл, түүний төлөөлөл	26
2.1.3. Хуулийн этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлагын төрөл	30
2.1.4. Эрүүгийн хариуцлага оногдуулах гэмт хэргийн төрөл	33
2.2. Гадаадын зарим орны туршлага: Бүгд Найрамдах Эстони Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс	41
Гурав. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ	45
3.1. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй өнөөгийн байдал (2017-2021 оны 6 дугаар сар)	45
3.2. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд тулгамдаж байгаа асуудал	52

ДҮГНЭЛТ	56
ЗӨВЛӨМЖ	63
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	65
ХАВСРАЛТ	69

ТОВЧИЛСОН ҮГ

НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУЭШХ	Олон улсын эрдэм шинжилгээний хурал
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ФСЭЗХ	Философи, социологи, эрх зүйн хүрээлэн
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШУА	Шинжлэх ухааны академи

НЭГ. УДИРТГАЛ

1.1. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ ОНОЛЫН ЧИГ ХАНДЛАГА

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал нь Англи-Америкийн эрх зүйн тогтолцоо бүхий АНУ, Англи, Канад зэрэг улсад үйлдвэрлэлийн хувьсгал хүчтэй өрнөсөнтэй холбоотойгоор 19 дүгээр зуунд үүссэн ойлголт юм.¹ Тухайлбал, Английн шүүх 1842 онд “Бирмингем болон Глостер” гэсэн нэртэй төмөр замын компанид эрүүгийн хариуцлага хүлээлгэж торгох ял оногдуулсан байдаг.

Дэлхий дахинд эдийн засгийн харилцаа либералчлагдаж, хуулийн этгээдийн хууль бус үйл ажиллагаатай холбогдон байгаль орчин, хүнсний аюулгүй байдал, хээл хахууль, хүний болон зэвсгийн наймаа, цахим аюулгүй байдал, бусдын нэр төр, нууцад халдах зэрэг шинэ төрлийн гэмт хэрэг олноор гарах болсон.

Эдгээр гэмт хэргийг зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор дэлхийн улс орнууд “*Corporate Criminal Liability*” буюу “компанид хүлээлгэх эрүүгийн хариуцлага” гэх нэр томъёог эрүүгийн эрх зүйн салбар шинжлэх ухаанд оруулж ирснээр энэхүү маргаантай ойлголт судлаачдын анхаарлын төвд орж ирсэн түүхтэй. Хуулийн этгээд нь хийсвэр бөгөөд өөрөө бие-сэтгэхүйн хувьд гэмт хэрэг үйлдсэн байх боломжгүй нь маргаангүй хэдий ч түүнийг төлөөлөн үйлдэл хийж буй хувь хүн, тэдгээрийн нэгдэл нь тухайн хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, түүний ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн байдаг нь уг хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болдог. Өөрөөр хэлбэл, компанийн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх

¹ Маркус Вагнер, Корпорацын эрүүгийн хариуцлага, “Эрүүгийн хуулийн шинэчлэлийн асуудал” сэдэвт олон улсын бага хуралд тавигдсан илтгэл, 1999, 2 дахь тал.

нь бусад хариуцлагын тогтолцооноос үр дүнтэй байгааг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч “Зөвхөн хувь хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэсэн эрүүгийн эрх зүйн зарчмаас татгалзах болсон юм.

Олон улсын гэрээ, конвенцод ч хуулийн этгээд гэмт хэргийн субъект болохыг хүлээн зөвшөөрсөн байна. Тухайлбал, Авлигын эсрэг НҮБ-ын конвенц,² НҮБ-ын Палермогийн конвенц³, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц зэргээс харагдаж байна. Түүнчлэн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг Эрүүгийн хуульдаа тусгасан орнуудын тоо жил бүр нэмэгдсээр байна.

Эрүүгийн эрх зүйд хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага гэдэг ойлголтыг тухайн хуулийн этгээд нь түүнийг төлөөлөн өөрийн ажилтны хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн төлөө эрүүгийн хариуцлага хүлээхийг хэлнэ гэж тодорхойлдог. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан, ажилтан хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн бол тухайн хуулийн этгээд эрүүгийн хариуцлагын субъект болохыг хэлж байгаа юм.⁴

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл буюу хуулийн этгээдийг хамтын хариуцлагын субъект (гэмт хэргийн субъект) гэж үзэж болох үндэслэлийг Францын эрдэмтэн Р.Мерль, А.Витю нар дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

² Тус конвенцын 26 дугаар зүйлийн хуулийн этгээдийн хариуцлага гэсэн бүлэгт “1. Оролцогч улс бүр эрх зүйн зарчимдаа нийцүүлэн энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэрэгт оролцсон хуулийн этгээдэд хариуцлага тогтооход шаардлагатай байж болох арга хэмжээг авна. 2. Оролцогч улсын эрх зүйн зарчмуудаас хамааран хуулийн этгээдийн хариуцлага эрүүгийн, иргэний юм уу захиргааны байж болно. 3. Ийм хариуцлага нь гэмт хэрэг үйлдсэн хувь хүний эрүүгийн хариуцлагыг хөндөхгүй. 4. Оролцогч улс бүр ялангуяа энэ зүйлийн дагуу хариуцлага хүлээх хуулийн этгээдэд үр дүнтэй, тухайн үйлдэлд тохирох, тухайн үйлдлийг хийхгүй байлгах эрүүгийн болон эрүүгийн бус шийтгэл, түүний дотор мөнгөн торгуулийн шийтгэл ногдуулна.

³ Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц (2004)-ын 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

⁴ https://www.researchgate.net/publication/309041784_THE_CASE_FOR_CORPORATE_CRIMINAL_LIAB

- Хуулийн этгээдийг төлөөлөх коллеги, зөвлөлийн хамтын шийдвэрээр уг үйлдлийг дэмжсэн ба санаачлан үйлдсэн байх;
- Удирдах буюу эрх бүхий албан тушаалтны гэмт үйлдэлтэй давхардаагүй буюу тусдаа бүрэлдэхүүнтэй байх;
- Хуулийн этгээдэд ашигтай боловч бусдад хохирол, үр дагавар учруулсан байх;
- Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс хийгдсэн байх.⁵

Харин Дэлхийн Эрүүгийн загвар хуульд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх онолын үндэслэлийг дараах байдлаар тайлбарласан.

- а) Хуулийн этгээдийн нэр дээр, нэрийн өмнөөс эсвэл түүний ашиг тусын төлөө гэмт хэрэг үйлдэгдсэн.
- б) Хуулийн этгээд болох байгууллагын бүлэг хүн эсхүл хувь хүнээр үйлдэгдсэн байх бөгөөд тэрхүү этгээд нь тухайн хуулийн этгээдийн хувьд менежментийн болон хяналтын байр суурьтай байх. Үүнд:
 - Хуулийн этгээдийг төлөөлөх эрх мэдэл бүхий этгээд;
 - Хуулийн этгээдийн өмнөөс шийдвэр гаргах албан тушаалтан;
 - Хуулийн этгээдийн дотоодод хяналт тавих албан тушаалтан.

Хуулийн этгээд нь хувь хүний хяналт муу байсантай холбоотой үйлдэгдсэн гэмт хэргийн тухайд эрүүгийн хариуцлага хүлээж болно. Ингэхдээ тэрхүү үйлдэл нь хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн гэмт хэрэг байна⁶ гэжээ.

⁵ Д.Баярсайхан, Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага, УБ., 2013, 34 дэх тал.

⁶ Дэлхийн Эрүүгийн загвар хууль (*Model Criminal Code for Post-conflict criminal justice*), 2007.

Хуулийн этгээд болох компанид эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал нь онолын хувьд:

- Үүсмэл хариуцлага;
- Байгууллагын хариуцлага гэсэн хоёр төрөл байна.⁷

Үүсмэл хариуцлага нь дотроо:

- Төлөөлөн хүлээлгэх хариуцлага (АНУ);
- Адилтгалын хариуцлага (Англи) гэж хуваагддаг.⁸

Төлөөлөн хүлээлгэх хариуцлага (*Vicarious liability*) нь тухайн компани бүх ажилтныхаа өмнөөс эрүүгийн хариуцлага хүлээдэг.⁹ Тухайлбал, АНУ-д корпорацад эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ тухайн компанийн ямар ажилтан гэмт хэрэг үйлдсэн гэдгээс үл хамааран эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна. Тэгэхдээ тухайн ажилтан нь өөрийн ажлын цар хүрээний дотор, тухайн компанийн ашиг тусын төлөө санаатайгаар гэмт хэрэг үйлдсэн байвал корпорац эрүүгийн хариуцлага хүлээнэ гэсэн үзэл баримтлалыг мөрдлөг болгодог.

Адилтгалын хариуцлага (*Identification liability*) нь зөвхөн удирдах түвшний ажилтны хийсэн үйлдэлд компани хариуцлага хүлээдэг. Жишээ нь, Англи, Австрали, Канад зэрэг зарим улсад зөвхөн гүйцэтгэх захирал болон ахлах менежер гэх мэт удирдах түвшний ажилтны гэмт үйлдлийн төлөө корпорац эрүүгийн хариуцлага хүлээдгээрээ харьцангуй хязгаарлагдмал шинжтэй гэж үзэж болох юм.¹⁰ Монгол Улс адилтгалын загвар (Английн загвар)-ыг хуульчилсан нь Эрүүгийн хуульд заасан “Хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан өөрөө эсвэл зөвшөөрөл өгч бусдаар үйлдүүлсэн” гэсэн заалтаас харагдаж байна.

⁷ Б.Одонгэрэл, “Монгол Улсад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь” магистрын ажил, Кюүшүгийн их сургуулийн Хуулийн сургууль, 2011.

⁸ Дэлхийн Эрүүгийн загвар хууль (*Model Criminal Code for Post-conflict criminal justice*), 2007.

⁹ Б.Одонгэрэл, “Монгол Улсад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь” магистрын ажил, Кюүшүгийн их сургуулийн Хуулийн сургууль, 2011.

¹⁰ Мөн тэнд.

Байгууллагын хариуцлага нь тухайн компанийн бодлого, эрх хэмжээ, үйл ажиллагаа, хандлага зэрэгт тулгуурлан тухайн компанид эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна.

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ улс орнууд онолын гурван чиг хандлагад суурилан дараах загварын дагуу эрх зүйн тогтолцооныхоо онцлогт тохируулан нутагшуулан хуульчилж байна.

Америкийн загвар. Төлөөлөн хүлээлгэх хариуцлагын зарчим нь шууд бус хариуцлага буюу аливаа этгээд өөр нэгний буруутай үйл ажиллагааны өмнөөс төлөөлж, хариуцлага хүлээж буй нөхцөл байдлаар илэрнэ. Энэ онолын гол төлөөлөгч нь АНУ бөгөөд доорх хоёр нөхцөл бүрдсэн байвал удирдлагын тогтолцоог үл харгалзан бүх ажилтныхаа үйлдсэн гэмт үйлдэл, эс үйлдэхүйн төлөө хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээнэ.¹¹

1. Тухайн ажилтан өөрийн ажил үүргийн хүрээнд үйлдсэн байх;
2. Хуулийн этгээдийн эрх ашгийн төлөө хийсэн үйлдэл, эс үйлдэхүй байх.

Ажил олгогч буюу хуулийн этгээд хэн нэгнийг эдийн засгийн ашиг олох зорилгоор ажиллуулдаг тул ажилтны хөдөлмөрийн харилцааны улмаас учруулсан хохирол, үйлдсэн гэмт хэргийн төлөө хуулийн этгээдийг шийтгэх нь шударга явдал юм. Учир нь ажил олгогч, ажилтан хоёрын харилцааны үр шимийн дийлэнхийг ажил олгогч хүртдэг.¹²

Энэ загварын тухайд хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээх үндэслэлийг өргөн хүрээнд тодорхойлж өгсөн бөгөөд ажилтны хуулийн этгээд дэх албан тушаалын байр сууриас үл хамааран тухайн гэмт үйлдлийнх нь төлөө хуулийн этгээдэд төлөөлөн хариуцлага хүлээлгэдгээрээ онцлогтой.

Энэхүү загварын давуу тал нь байгууллага дотооддоо гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж, нийт ажилтны хариуцлагыг өндөржүүлэн, дор бүрнээ хянамгай байж, энэ нь эцэстээ хуулийн

¹¹ Мөн тэнд.

¹² Дэлхийн Эрүүгийн загвар хууль (*Model Criminal Code for Post-conflict criminal justice*), 2007.

этгээдийн соёл төлөвшин тогтоход ач холбогдолтой гэж судлаачид үздэг.¹³ Харин түүний сул тал нь урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан хэдий ч хэн нэгэн хариуцлагагүй ажилтны хайхрамжгүй байдлаас үүдэн хуулийн этгээд хариуцлага хүлээж буй явдал бөгөөд энэ нь ажилтны үйлдэл бүрийг хянах боломжгүй байдагтай холбоотой гэж судлаачид үздэг.¹⁴

Английн загвар. Адилтгалын онолд суурилсан энэ загвар нь хуулийн этгээдийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг тодорхой ажилтны үйлдлийг тухайн хуулийн этгээдийн үйлдэлтэй адилтган үздэг. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйлдсэн гэм буруутай үйлдэл, эс үйлдлийн төлөө хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээх нь адилтгалын онолын онцлог юм. Энэхүү үзэл баримтлал нь хуулийн этгээдийн эрх бүхий өндөр албан тушаалтныг “*корпорацийн оюун санаа, төлөв байдал*” гэж үздэг тул түүний үйлдлийг хуулийн этгээд гэмт хэрэг үйлдсэнтэй адилтган тооцож, шууд ял оногдуулах боломжтой гэсэн чиг хандлага юм.

Энэхүү зарчимд компанийн удирдах ажилтан нь тухайн компанийн “*чиглүүлэх оюун ухаан (directing mind)*”-ыг төлөөлдөг гэж үздэг. “*Graham & Sons*” ХХК-ийн хэрэг дээр Лорд Деннинг энэхүү зарчмыг тодорхой тайлбарласан байдаг.¹⁵ Тэрээр “Хүний тархи бол төв мэдрэлийн төв, харин гар нь багаж хэрэгсэл барьж, аливаа чиглэлд нийцүүлэн ажиллах чадвартай байдаг шиг компанийн чиглүүлэх оюуныг барьж буй хариуцлагатай өндөр албан тушаалтнууд бол хүний тархитай нэгэн адил” гэж хэлжээ. Түүнчлэн “Компанийн зарим ажилтан яг л “хүний гар” шиг үйлчлэгч, төлөөлөгч байдаг бөгөөд тэд зөвхөн ажлаа л хийдэг учраас компанийн оюун ухаан, хүсэл зоригийг төлөөлөхгүй төдийгүй тэдний үйлдэл хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болдоггүй” гэжээ.¹⁶ Тэрээр цааш нь “Ер нь гол төлөв захирлуудын зөвлөл, өөрөөр хэлбэл, удирдаж буй захирал, мэдээж

¹³ Эрүүгийн эрх зүйн шинэтгэл: Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал, УБ., 2017, 49 дэх тал.

¹⁴ Мөн тэнд.

¹⁵ Мөн тэнд.

¹⁶ Mark Pieth, Radha Ivory, Corporate Criminal Liability, Springer Science and Business Media B.V. 2011.

хэрэг, компанийн бусад удирдах албан тушаалтан өөрсдөө компани мэт ярьж, хөдөлж байдаг” гэжээ.¹⁷ Энэ нь хуулийн этгээд бол хийсвэр зүйл тул хуулийн этгээдийн хувьд түүнийг төлөөлөн шийдвэр гаргаж, бусдад даалган, бусдаар үйлдүүлж буй албан тушаалтны үйлдлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээнэ гэдгийг баталсан онол юм.

Энэхүү онолын сул тал нь хуулийн этгээдэд хэн нь эрх бүхий этгээд болохыг тогтооход хүндрэлтэй байдаг. Учир нь компанийн хувьд олон асуудал доод, дунд шатны менежерийн түвшинд шийдвэрлэгддэг тул дээд шатны албан тушаалтан хуулийн этгээдийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй байх нь элбэг. Иймд үүнийг дээд шатны буюу удирдах түвшний албан тушаалтан үйлдсэн гэж үзэхэд хүндрэлтэй байх нь бий.¹⁸ Өөрөөр хэлбэл, онолын энэ загвар нь цөөн ажилтантай жижиг, дунд хуулийн этгээдийн хувьд тохиромжтой боловч үндэстэн дамнасан корпорац, томоохон хэмжээний компанийн хувьд удирдах, гүйцэтгэх албан тушаалтан чухам хэн нь болох, тэдний шийдвэр, үйлдлээс болж гэмт хэрэг үйлдэгдсэн эсэхийг нотлоход хүндрэлтэй байдаг.¹⁹

Австралийн загвар. Хуулийн этгээдийн дотоодод тогтсон соёл, үйл ажиллагаа, хандлага нь гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлсөн бол хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Өөрөөр хэлбэл, тухайн компанийн дүрэмд заасан компанийн бодлого, зорилго, чиг үүрэг, зарчим, үйл ажиллагаа нь хуулийн этгээдийг гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн байдаг.²⁰ Хуулийн этгээд дотооддоо гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хангалттай арга хэмжээ авч ажиллаагүй бол ажилтны үйлдэж байгаа гэмт үйлдэл нь хуулийн этгээдийн соёл, хандлагыг харуулж байдаг. Иймд хуулийн этгээдийн бодлого, дүрэм журам, шийдвэр, төлөвшилт, үйл ажиллагаа зэрэг нь хуулийн этгээд болон түүний ажилтны мэдлэг, санаа зорилго, үйл ажиллагааг илтгэн харуулах гол нотлох баримт болно.²¹

¹⁷ Tesco Supermarkets Ltd. v. Nattrass, 1972 App. Cas. 153 at 171.

¹⁸ Эрүүгийн эрх зүйн шинэтгэл: Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал, УБ., 2017, 50 дахь тал.

¹⁹ Мөн тэнд.

²⁰ Мөн тэнд. 26 дахь тал.

²¹ Model Criminal Code Officers and Criminal Law Officers' Committee of Standing Committee of Attorney General, Final Report: Chapter 2-General principles of Criminal responsibility, 1992, 104-108 дахь тал.

Америкийн загварын давуу тал нь байгууллага дотооддоо гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж, нийт ажилтны хариуцлагыг өндөржүүлэн, дор бүрнээ хянамгай байдал бий болгосноор эцэстээ хуулийн этгээдийн соёл төлөвшин тогтоход ач холбогдолтой байдаг бол Английн загвар нь төлөөлөх эрх бүхий этгээдийн үйлдэл нь хуулийн этгээдийн үйлдэлд тооцогддог тул цөөн ажилтантай жижиг, дунд хуулийн этгээдийн хувьд тохиромжтой. Харин үндэстэн дамнасан корпорац, томоохон хэмжээний компанийн хувьд удирдах, гүйцэтгэх албан тушаалтны хэн нь чухал болох, тэдний ямар шийдвэр, үйлдлээс болж гэмт хэрэг үйлдэгдсэн болохыг нотлоход хүндрэлтэй тал байх нь бий. Монгол Улсын тухайд Английн загварыг сонгож хэрэглэсэн нь нийт хуулийн этгээдийн 78.3 хувийг харьцангуй цөөн ажилтантай хуулийн этгээд эзэлж²² байгаа өнөөгийн нөхцөлд тохиромжтой загвар гэж үзэх, дүгнэх боломжтой.

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд онолын хувьд маргаантай нэг асуудал нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн этгээдийг хэрхэн тодорхойлох тухай асуулт байдаг. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн этгээд нь хувийн болон нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн аль төрөлд хамаарах талаар улс орон бүр өөр өөрийн онцлогоор хуульчилж, эрдэмтэн судлаачид янз бүрийн санал дэвшүүлдэг. Судлаачид хувийн эрх зүйн хуулийн этгээд эрүүгийн хариуцлагын субъект болох талаар маргадаггүй, харин нийтийн эрх зүйн хуулийн этгээд энд хамаарах эсэх талаар өөр өөрийн чиг хандлагыг баримталдаг. Тухайлбал, Англи, АНУ, Франц, Дани зэрэг зарим улсад нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байхад БНХАУ, Литва, Молдова, Норвег, Эстони зэрэг зарим оронд зөвхөн хувийн эрх зүйн хуулийн этгээдийг гэмт хэргийн субъект гэж үзэх нь бий. Өөрөөр хэлбэл, позитив онолын хандлагаар Бельги, Дани, Франц, Исланд зэрэг зарим оронд хувийн хуулийн этгээдээс гадна нийтийн эрх зүйн хуулийн этгээд болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага гэмт хэргийн субъект болдог бол Ирак, Хятад, Литва, Молдова, Норвег, Эстони зэрэг оронд зөвхөн хувийн эрх зүйн хуулийн

²² Улсын бүртгэлийн ерөнхий газрын тоон мэдээг ашиглав.

этгээд, тэр тусмаа арилжааны компаниуд эрүүгийн хариуцлага хүлээх субъект болдгоороо онцлогтой.²³

Эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн этгээдийн ангиллын асуудалд хэрхэн хандаж байгаагаар нь дэлхийн улсуудыг гурван чиг хандлагад хуваан авч үзэж болох юм. Үүнд, (i) ямар нэгэн тодорхойлолт, хязгаарлалтгүйгээр авч үздэг; (ii) эрүүгийн хариуцлага хүлээх хуулийн этгээдийн төрлийг жагсаасан; (iii) иргэний хуулиар хуулийн этгээд гэж тодорхойлогдсон статустай байгууллагад эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг.²⁴

Нэгдүгээрт, Эрүүгийн хуульд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг тодорхойлсон боловч “ямар” байгууллага байхыг заагаагүй, ерөнхийлөн зохицуулсан улсууд байна. Тухайлбал, Австралийн 1995 оны Эрүүгийн хуульд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай хуульчлахдаа “хуулийн этгээд” нь хэн байхыг тусгайлан зохицуулаагүй. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээд гэж ямар төрлийн байгууллага байхыг онцгойлон тодорхойлохоос зайлсхийсэн. Австралийн Эрүүгийн хуулийн 12.1 дэх хэсэгт “Хуулийн этгээдэд хувь хүний нэгэн адил эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэсэн байх ба “хуулийн этгээд” гэж “хэн” байхыг тодорхойлоогүй.²⁵

Монгол Улсын хувьд үүнтэй адил “хуулийн этгээд” гэж хэнийг хамруулж ойлгохыг Эрүүгийн хуулиар тодорхойлохгүйгээр “Хуулийн этгээдэд гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэмт хэргийн шинж, хохирол, хор уршгийн хэмжээг харгалзан энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ”²⁶ гэж ерөнхийлөн томъёолсон нь хууль хэрэглэгчдэд төөрөгдөл үүсгэж байна. Иймд Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэх хуулийн этгээдийн төрлийн талаар нэг мөр ойлголт өгөх хэрэгцээ шаардлага байна.

²³ Мөн тэнд.

²⁴ Б.Одонгэрэл, Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээх хуулийн этгээд, түүний төлөөллийн асуудал, “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүлийн 2018 оны 4 дугаарт.

²⁵ Австралийн Эрүүгийн хуулийн 12.1 дэх хэсэг, 1995.
<http://scaleplus.law.gov.au/html/pasteact/1/686/pdf/CriminalCode1995.pdf>

²⁶ Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Энэ зүйлийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан.

Хоёрдугаарт, улс орнууд хуулийн этгээдэд хэн хамрахыг хуулиар тодорхойлж хуульчилсан байдаг ба үүний нэг жишээ нь АНУ юм. АНУ-ын “Холбооны Ял шийтгэлийн удирдамж”-д хуулийн хариуцлага хүлээх субъект болох байгууллагыг тодорхойлсон байдаг. “Байгууллага” гэж хувь хүнээс бусад этгээдийг хэлэх ба энэхүү ойлголтод корпорац, нөхөрлөл, хувь нийлүүлсэн компани, нэгдэл, тэтгэмжийн сан, нэгдмэл бус байгууллага, Засгийн газрын байгууллага, улс төрийн нам, төрийн бус байгууллага хамаарна²⁷ гэжээ. Гэхдээ Засгийн газрын чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбоотой үйлдсэн төрийн байгууллагын гэмт хэргийн шинжтэй үйлдэлд эрүүгийн хариуцлага оногдуулахгүй гэж заасан. АНУ-д нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг нь эрх зүйн дээрх зохицуулалтаас харагдаж байгаа ба тухайлбал, 1922 онд Улсын Дээд шүүхээс Юнайтэд Майн Вокэрс болон Коронадо Көүл компанийн хэргийг шийдэхдээ Худалдааны холбоо Эрүүгийн хуулийг зөрчсөн гэж үзээд эрүүгийн хариуцлага оногдуулжээ.

Англид Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах тусгай хуулиар “Байгууллага гэдэг нь Засгийн газрын агентлаг, яам, газрууд, цагдаагийн хүчин, төрийн бусад байгууллага” гэж тодорхой заасан.²⁸ Түүнчлэн Канад Улсад 2004 оны нэмэлт өөрчлөлтөөр Эрүүгийн хуулийн хоёрдугаар зүйлд “Эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн этгээдэд төрийн байгууллага, корпорац, компани, нийгэмлэг, фирм, нөхөрлөл, нийтэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг нэгдлүүд буюу нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг хамруулан ойлгоно” гэж заажээ.²⁹

Францын Эрүүгийн хуулийн 121-2 дахь хэсэгт “...төрөөс бусад хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээнэ...” гэсэн нь төрийн байгууллагаас бусад нийтийн эрх зүйн хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээх субъект болохоор хуульчилжээ.³⁰ БНХАУ-д хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь “нэгжийн гэмт хэрэг” гэсэн ойлголтоор илэрхийлэгддэг. “Нэгж”-д зөвхөн хувийн эрх зүйн хуулийн этгээд болох компани, аж ахуйн нэгжээс гадна нийтэд чиглэсэн үйл ажиллагаа эрхэлдэг их, дээд сургууль, эмнэлэг зэрэг төрийн болон төрийн бус

²⁷ АНУ-ын Холбооны Ял шийтгэлийн удирдамж, 8А 1.1. (2004).

²⁸ Корпорацын хүний амины гэмт хэргийн тухай хууль, 2007, 19 дүгээр зүйл.

²⁹ Канадын Эрүүгийн хуулийн 46 дугаар бүлэг, 2 дугаар зүйл, 2005.

³⁰ Mark Pieth, Radha Ivory, Corporate Criminal Liability (*Emergence, convergence, and Risk*), Springer Science and Business Media B.V. 2011.

байгууллага нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн ба тэрхүү гэмт хэргийг нь хуульд тэдгээр нэгжийн үйлдэх гэмт хэрэг гэж тодорхойлсон бол тэдэнд эрүүгийн хариуцлага оногдуулна” гэж тодорхой заажээ.³¹

Гуравдугаарт, хуулийн статустай, статусгүй хуулийн этгээдийн аль алиныг хамааруулдаг. Европын зарим эрх зүйн тогтолцоонд, тухайлбал, Франц, Дани зэрэг улсын хуулиудад зөвхөн хуулийн этгээдийн эрх зүйн статустай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг бол Нидерланд Улсад илүү орчин үеийн чиг хандлага баримтлан, хуулийн статусгүй этгээдийг Эрүүгийн хуулийн субъект гэж хуульчилсан нь бий.

Дээрх улсуудын жишгээс харахад хоёрдугаар чиг хандлага буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн этгээдийн төрлийг хууль, удирдамж зэргээр тодорхой заасан байх нь түгээмэл байна. Өөрөөр хэлбэл, АНУ, Англи, Канад, Франц, Дани, Исланд зэрэг оронд “хуулийн этгээд” гэж “хэн” болохыг заасан төдийгүй зөвхөн компани гэлтгүй нөхөрлөл, ашгийн төлөө бус байгууллага, сайн дурын нэгдэл, төр-хувийн хэвшил бүхий нөхөрлөл зэргээр нийтэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах нийтийн эрх зүйн этгээдийг хамруулсан байна. Харин төр, Засгийн газар, түүний харьяа байгууллагыг эрүүгийн хариуцлагын субъект гэж үзэх нь харьцангуй цөөн боловч нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага гэмт хэргийн субъект болох нь бий. Хятад, Литва, Молдова, Норвег, Ирак, Эстони зэрэг оронд зөвхөн хувийн эрх зүйн этгээд тэр тусмаа арилжааны компаниуд эрүүгийн хариуцлага хүлээх субъект болдог онцлогтой байна.³²

1.2. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Зөвхөн хувь хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрүүгийн эрх зүйн уламжлалт зарчим олон жил ноёрхож ирсэн Монгол Улсад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь шинэ тутам ойлголт юм. Тиймээс үүнийг судлахдаа Эрүүгийн хуульд заасан эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт, тулгамдаж буй асуудлыг илрүүлэн, түүнийг шийдвэрлэх арга зам эрэлхийлэхийг зорилоо.

³¹ БНХАУ-ын Эрүүгийн хууль, 30 дугаар зүйл.

³² Д.Баярсайхан, Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага, УБ., 2013, 98 дахь тал.

1990 оноос зах зээлийн харилцаанд шилжсэнтэй холбоотой үүсэж бий болсон хуулийн этгээдийн гэмт хэргийн асуудал 1998 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулж байх үед хөндөгдөж байсан боловч гадаад орнуудын онол, шүүхийн практикийн талаар тоймтой судалгаа, мэдлэг туршлага дутмаг байсны улмаас олонхын дэмжлэг аваагүй байна.³³ 2010 онд Хууль зүйн үндэсний хүрээлэн анх удаа хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар гадаад, дотоодын эрдэмтэн, судлаачдын дунд олон улсын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, тус хурлаар доктор Г.Гантөмөр, Д.Баярсайхан, Б.Одонгэрэл нар Монгол Улсад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хэрэгцээ шаардлага, үндэслэл бүхий саналыг илтгэлээрээ дэвшүүлж байжээ. Үүний дараа Хууль зүйн үндэсний хүрээлэн, ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэн хамтран Монголын 200 гаруй хуульчийн дунд “Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал”-аар санал асуулгын судалгаа явуулахад нийт оролцсон хуульчдын 78.9 хувь нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх байр суурийг илэрхийлсэн бол 9.3 хувь нь одоогоор цаг нь болоогүй, 2.9 хувь нь шаардлагагүй, 8.8 хувь нь энэ талаар хэлж мэдэхгүй байна гэж хариулжээ.³⁴ Иймд тус судалгааг гүйцэтгэсэн судлаачдын зүгээс хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэсэн байр суурийг манай улсын хуульчид илэрхийлж байна гэж дүгнэсэн байдаг.³⁵

Монгол Улсын Эрүүгийн хуулийн есдүгээр бүлгийн зүйл, заалтуудыг судлан шинжлэхийн зэрэгцээ эрх зүйн тогтолцоо ойролцоо, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа туршлага нь шинэ тутам Эстони, Вьетнам улсуудын Эрүүгийн хуулийн зохих заалттай харьцуулан судлав.

Мөн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхдээ 2015 оны Эрүүгийн хууль

³³ Г.Гантөмөр, Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын зарим асуудал, “Гэмт явдалтай тэмцэх” асуудал сэтгүүл, 2007 оны №1, 22 дахь тал.

³⁴ Д.Энхболд, Ц.Жаргал, Б.Одонгэрэл, Монгол Улсад хуулийн этгээд болох компанид эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлын талаарх социологийн судалгаанд анализ хийх нь, “Эрдмийн ертөнц” сэтгүүл (ШУА, ФСЭЗХ), 2011 оны 1(4).

³⁵ Мөн тэнд.

үйлчилж эхэлсэн өдөр буюу 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх цагдаа, прокурорын байгууллага, шүүхийн статистик мэдээг ашиглав. Түүнчлэн Монгол Улсын хэмжээнд дөрвөн жилийн хугацаанд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах шийдвэр гаргасан нийт найман шүүхийн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулахад тулгамдаж байгаа асуудлыг тодруулах зорилгоор 103 шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгчөөс санал асуулгын судалгаа авахын зэрэгцээ 25 шүүгч, прокуророос ганцаарчилсан ярилцлагын судалгаа авсан болно. Улс оронд болж буй Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор нүүр тулан ярилцлага авах боломжгүй байсан хэдий ч утсаар болон онлайн аргаар ярилцлагын судалгааг амжилттай хийж гүйцэтгэлээ.

Санал асуулгын болон ярилцлагын судалгаанд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байсан туршлагыг үндэслэн нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй, Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргүүд, хөдөө орон нутгаас Баянхонгор, Өмнөговь, Хэнтий (Бор-Өндөр), Өвөрхангай аймгуудын шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгчдийг хамруулав.

Энэхүү судалгааны хүрээнд дэвшүүлсэн асуудал нь:

- Монгол Улсад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт оновчтой эсэх;
- Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй өнөөгийн нөхцөл байдлыг судлан шинжлэх;
- Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд тулгамдаж буй асуудлыг илрүүлэх;
- Тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох явдал байв.

ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын хувьд 2015 оны Эрүүгийн хуулийн (шинэчилсэн найруулга) есдүгээр бүлгээр хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг иж бүрэн хуульчилсан ба тус хууль мөрдөгдөж эхлээд дөрвөн жилийн нүүр үзэж байна. Үүнээс өмнө буюу 2014 оны нэгдүгээр сард 2002 оны Эрүүгийн хуульд анх удаа “Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ”³⁶ гэсэн заалт нэмэлтээр оруулж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэсэн хоёр зүйлд “Энэ гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол ...торгох ял шийтгэнэ” гэж хуульчилсан. Хэдийгээр дээрх хоёр гэмт хэргийн тухайд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин бүрдсэн боловч шинэ Эрүүгийн хууль хэрэгжиж эхлэх хүртэл шүүхээр энэ төрлийн хэрэг хянан шийдвэрлэгдээгүй нь хуулийн этгээдийн зүгээс үйлдэгдсэн байх боломжтой гэмт хэргийг бүрэн хуульчлаагүйтэй холбоотой гэж үзлээ.

2.1. МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

Монгол Улсын Эрүүгийн хуулийн есдүгээр бүлгийн 9.1 дүгээр зүйлд³⁷ зааснаас гадна ерөнхий ангийн зарим зүйл заалтад дараах байдлаар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай хуульчлан заасныг тодруулбал: (i) Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд заасан шударга ёсны зарчмын 1-д “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн,

³⁶ Эрүүгийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, 2002, “Төрийн мэдээлэл”, 2002 оны №6.

³⁷ Эрүүгийн хууль, 2015, “Төрийн мэдээлэл”, 2016 оны №7.

хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна”; (ii) мөн тус зүйлийн 4-т “Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй”; (iii) тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 4-т “Энэ хуульд заасан тохиолдолд Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэсэн бол (iv) 1.8 дугаар зүйл буюу Хууль үйлчлэх цаг хугацааны 1-д “Үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцох, гэм буруутай хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тухайн гэмт хэргийг үйлдэх үед дагаж мөрдөж байсан хуулиар тодорхойлно” гэж тус тус заасан. Дээрх заалтуудаас харахад Эрүүгийн хууль нь хуулийн этгээдэд хувь хүнтэй адил зарчмаар үйлчлэхийг заасан зохицуулалтууд юм.

Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагын зорилгыг тодорхойлохдоо “...гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино”³⁸ гээд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэж заасан. Энэ нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ нийт гэмт хэргийн тухайд бус “зөвхөн тусгай ангид заасан байх” гэсэн үндэслэлийг тодорхойлжээ. Түүнчлэн Эрүүгийн хуулиар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд “хуулийн хийдэл” үүсгэж байсан нэг асуудал нь хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох аргачлал тодорхой бус байсан юм. Эрүүгийн хуулийн 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг “Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэж энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бол тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно” гэж заасан нь хэрэг хянан шийдвэрлэх

³⁸ Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйл, “Төрийн мэдээлэл”, 2016 оны №7.

ажиллагаанд нэг мөр болоогүй эргэлзээтэй байсан хуулийн хийдлийг засаж чадсан заалт болжээ.³⁹

Эрүүгийн хуулийн есдүгээр бүлгийг “Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх” гэж тусгайлан нэрлэж түүний бүтцэд (i) Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл; (ii) Хуулийн этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлагын төрөл: торгох ял, эрх хасах албадлагын арга хэмжээ, татан буулгах албадлагын арга хэмжээ, хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ; (iii) Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага гарцаагүй байх гэсэн гурван үндсэн ойлголтыг багтааж өгсөн.

2.1.1. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг Эрүүгийн хуулийн есдүгээр бүлгийн 9.1 дүгээр зүйлийн 2-т “Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд ял оногдуулахаар заасан гэмт хэргийн шинжийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа, эсхүл хамтран шийдвэр гаргаж, эсхүл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан нь хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэл болно”⁴⁰ гэж тодорхойлжээ.

Дээрх заалтын дагуу хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нэг дэх үндэслэл бол хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа эсвэл хамтран шийдвэр гаргаж, үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан байх болно. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээх үндэслэл нь түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдийн хийсэн үйлдлийн өмнөөс төлөөлөн хариуцлага хүлээх билээ.

Хоёрдугаар үндэслэл нь хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө байх юм. Дээр дурдсан онолын гурван загварын алинд ч хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд хувь хүний үйлдсэн гэмт хэрэг нь

³⁹ Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг. Энэ хэсгийг 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн. “Төрийн мэдээлэл”, 2016 оны №7.

⁴⁰ Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2015, “Төрийн мэдээлэл”, 2016 оны №7.

хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн байх шинжийг агуулсан байдаг.

Гуравдугаар үндэслэл нь энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд ял оногдуулахаар заасан гэмт хэргийн шинжийг хангасан байх болно. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг байх гэсэн шинжийг ерөнхий ангийн 5.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт мөн хуульчилсан.

Мөн 9.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргаж, зөвшөөрөл өгч энэ хуульд заасан гэмт хэргийг бусдаар үйлдүүлсэн эсхүл хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй үйлдэл, эс үйлдэхүйгээр энэ хуульд заасан гэмт хэргийг үйлдсэн бол энэ хуульд заасан ял оногдуулна” гэж заасан. Ингэснээр хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан нь бусдаар гүйцэтгүүлсэн бол мөн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болохоор зохицуулжээ.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.2 дугаар зүйлд гэмт хэргийн гүйцэтгэгчийг тодорхойлохдоо “Хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргаж, зөвшөөрөл өгч энэ хуульд заасан гэмт хэргийг бусдаар үйлдүүлсэн, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө энэ хуульд заасан гэмт хэргийн шинжийг өөрийн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан бол гэмт хэргийн гүйцэтгэгчид тооцно” гэсэн нь хуулийн этгээдийн өмнөөс төлөөлөн гүйцэтгэсэн үйлдлийг хуулийн этгээдийн үйлдэлд тооцохыг бататгаж байна. Харин тухайн хуулийн этгээдийн гүйцэтгэх албан тушаалтан эрх бүхий албан тушаалтны өгсөн шийдвэрийг хууль бус болохыг мэдсээр байж үйлдсэн бол хамтран үйлдсэн гүйцэтгэгчид тооцогдохоор хуульчилснаараа онцлогтой.⁴¹

Дээрх заалтууд нь хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдийн бусдаар гүйцэтгүүлсэн гэмт үйлдэл,

⁴¹ Эрүүгийн хуулийн 3.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, “Төрийн мэдээлэл”, 2016, №7.

эс үйлдэхүйн өмнөөс хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээх үндэслэлийг харуулж байна.

Монгол Улсад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх дараагийн нэг зохицуулалт нь “давхар хариуцлага хүлээлгэх” тухай асуудал юм. 2015 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн шударга ёсны зарчимд “хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн бол тухайн хүнийг ялаас чөлөөлж, хуулийн этгээдэд ял оногдуулна”⁴² гэж хуулийн этгээдэд ял оногдуулсан бол тухайн хувь хүнийг ялаас чөлөөлөхөөр тусгасан байжээ.⁴³ Харин 2017 оны тавдугаар сард УИХ-аар баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалд “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх талаар санхүүгийн хориг арга хэмжээ авч хэрэгжүүлэх олон улсын байгууллагын шинэчилсэн 40 зөвлөмж”-ийн гуравдугаарт “хувь хүнд хариуцлага хүлээлгэсэн нь хуулийн этгээдийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй байх талаар хуульд тусгах шаардлагатай”⁴⁴ гэснийг дурдаж, Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан журмын дагуу хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгсөн эрх бүхий албан тушаалтныг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж хуульчилсан.

Энэ нь Монгол Улс Япон Улс, БНХАУ зэрэг Азийн зарим орнуудын нэгэн адил давхар хариуцлагын тогтолцоог хуульчилсан болохыг нотлон харуулж байна.⁴⁵ Түүнчлэн Эрүүгийн хуулийн шударга ёсны зарчмын дагуу хуульчлагдсан давхар хариуцлагын талаарх дээрх заалт нь “*Double non jeopardy*” буюу “Нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” гэсэн заалттай давхцаагүй зарчим болохыг Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан “Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн

⁴² Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга), 1.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, “Төрийн мэдээлэл”, 2016, №7.

⁴³ Эрүүгийн хууль, 2015, “Төрийн мэдээлэл”, 2016, №7.

⁴⁴ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, 2017. <http://mojha.gov.mn/uixd-huuli-tusul.html>

⁴⁵ Монгол Улсын нэгдэн орсон хэд хэдэн гэрээ конвенцод ийм заалт байгааг анхаарах нь зүйтэй.

хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй”⁴⁶ гэсэн заалтаас харагдаж байна.

Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт гадаад улсын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн бол энэ хуульд заасан хуулийн этгээдийн нэгэн адил эрүүгийн хариуцлага хүлээхээр хуульчилсан байна. Үүний зэрэгцээ эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмыг хангах үүднээс эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан ч эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгагдсан нь нэн зүйтэй заалт болжээ. Тухайлбал:

- Бусад хуулийн этгээдтэй нийлүүлэн нэг хуулийн этгээд үүсгэсэн бол шинээр бий болсон хуулийн этгээдэд;
- Бусад хуулийн этгээдэд нэгтгэсэн бол нэгтгэж авсан хуулийн этгээдэд;
- Хуваах, тусгаарлах замаар өөр хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол тухайн гэмт хэрэгт холбогдох эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, үйл ажиллагааг шилжүүлэн авсан хувь хэмжээгээр нь зохих хуулийн этгээдэд;
- Хуулийн этгээд нь зохион байгуулалтын төрөл, хэлбэр, үндсэн зорилгоо өөрчлөх замаар өөрчлөгдсөн бол тухайн өөрчлөн зохион байгуулагдсан хуулийн этгээдэд;
- Компани нь толгой компани, түүний үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлын үүднээс гэмт хэрэг үйлдсэн бол толгой компанид эрүүгийн хариуцлага оногдуулна.⁴⁷

Түүнчлэн “Хэргийг хянан шийдвэрлэх явцад хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагаас зайлсхийх зорилгоор санаатайгаар татан буулгасан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг эд хөрөнгө хуваарилагдсан хувьцаа эзэмшигчдэд, үндэслэлгүйгээр аливаа хэлбэр, арга, хэрэгслээр

⁴⁶ Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйл, 3 дахь хэсэг, “Төрийн мэдээлэл”, 2016, №7.

⁴⁷ Эрүүгийн хуулийн 9.7 дугаар зүйл, 1 дэх хэсэг, “Төрийн мэдээлэл”, 2016, №7.

эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг тухайн хуулийн этгээдээс шилжүүлэн авсан нэгдмэл сонирхолтой этгээд, эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг хариу төлбөргүйгээр шилжүүлсэн бусад хуулийн этгээдээс нөхөн гаргуулна”⁴⁸ гэсэн нь мөн л эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмын илрэл юм.

2.1.2. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн этгээдийн төрөл, түүний төлөөлөл

Монгол Улсын Эрүүгийн хуульд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг тодорхойлсон боловч “ямар” байгууллага байхыг заагаагүй ерөнхийлөн зохицуулсан. Иймд “Эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн этгээдийг Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1⁴⁹-д заасан хувийн эрх зүйн хуулийн этгээдээр хязгаарлан авч үзэх үү?” гэсэн асуулт гарч байна. Түүнчлэн төрийн байгууллага, нийтийн эрх зүйн хуулийн этгээд, шашны байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар зэрэг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлд заасан зарим хуулийн этгээд энд хамаарах эсэхийг тодруулах шаардлагатай.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны хуулийн үзэл баримтлалд “...мөн хариуцлагаас зайлсхийх зорилгоор хуулийн этгээд өөрчлөн зохион байгуулагдсан нөхцөлд эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмыг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байх тул төрийн байгууллага, хуульд зааснаар үүсгэн байгуулагддаг **нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх**, гадаад улсын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг хуулийн этгээдийн нэгэн адил авч үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай зохицуулалтыг нэмэх”⁵⁰ гэснээс харвал хууль тогтоогчдын үзэл санаа нь нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг Эрүүгийн хуульд заасан эрүүгийн

⁴⁸ Эрүүгийн хуулийн 9.7 дугаар зүйл, 2 дахь хэсэг, “Төрийн мэдээлэл”, 2016, №7.

⁴⁹ Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ.

⁵⁰ <http://forum.parliament.mn/files/11636> сайтаас авч ашиглав. Сүүлд зочилсон 2019.05.14.

хариуцлага хүлээх хуулийн этгээд гэж үзэхгүй гэдгийг илэрхийлсэн гэж үзэж болохоор байна.

Дэлхийн улсуудын туршлагаас үзэхэд хуулийн этгээд гэдэг ойлголтод зөвхөн ашгийн төлөө компани, корпорац зэргээс гадна ашгийн төлөө бус төрийн байгууллага, төрийн өмчит компани, түүнчлэн төрийн бус байгууллагыг ч хамруулан үзэх нь бий. Өөрөөр хэлбэл, зарим улсад нийтийн эрх зүйн хуулийн этгээд буюу ассоциаци, холбоо, сан, нам болон нэгдэл нь хуулийн этгээдийн хариуцлагаас мултран үлдэх ёсгүй. Учир нь тэд төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ тэрхүү байгууллагын үүрэг, зорилго, бодлого, үйл ажиллагааны дагуу үйлдлээ хийсэн байх ёстой гэж үздэг байна.⁵¹

Монгол Улсад 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 198,332 хуулийн этгээд бүртгэлтэй байгаагаас хувьцаат компани 301, хязгаарлагдмал хариуцлагатай компани 155,351, гадаадын хөрөнгө оруулалттай ХХК 9,090, нөхөрлөл 5,000, хоршоо 3,930, хадгаламж зээлийн хоршоо 553, сан 1,632, ТББ 22,565, төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 75, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 349, үйлдвэрчний эвлэлийн байгууллага 1,481, шашны байгууллага 546, хэвлэл мэдээллийн байгууллага 1,063, боловсрол сургалтын байгууллага 585 байна.⁵² Үүнээс хувийн эрх зүйн хуулийн этгээд буюу Иргэний хуулийн 25.1 дүгээр зүйлд хамаарагдах хувийн эрх зүйн хуулийн этгээд 88.6 хувь, нийтийн эрх зүйн хуулийн этгээд 21.4 хувийг эзэлж байна.

Дараагийн асуудал бол хуулийн этгээдийн удирдлага, түүний төлөөллийн тухай асуудал юм. Иргэний хуулийн 25 дугаар зүйлд заасан хувийн хуулийн этгээдийн үндсэн төрөл болох компани, нөхөрлөл, хоршоо зэргийн төлөөлөл, удирдлагыг хуулиар зохицуулсныг судлахад дараах байдалтай байна.

Компани нь хувийн эрх зүйн хуулийн этгээдийн гол төрөл болдог төдийгүй эдийн засгийн утгаараа нөхөрлөл, хоршоо, сан, холбоо гэх

⁵¹ Anca Iulia Pop, Criminal Liability of Corporations-Comparative Jurisprudence. www.law.msu.edu

⁵² Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн статистик тоон мэдээллийн сангаас авч ашиглав. 2020.03.25-ны өдрийн байдлаар.

мэт хуулийн этгээдийн бусад төрөл дотроос үйл ажиллагааны цар хүрээ өргөн, эрх ашиг нь хамааралтай этгээдийн тоо олон учраас маргаан гарахад эрх зүйн үр дагавар нь ноцтой, нийгэмд мэдрэгдэх байдал нь илүүтэй байдаг билээ.⁵³ Компанийн удирдлага нь тухайн компанийн итгэмжлэгдсэн этгээд байдаг бөгөөд түүнд тулгуурласан тодорхой эрх эдэлж үүрэг хүлээж, эрх зүйн харилцааны үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулж хэрэгжүүлдэг. Энэ нь тухайн албан тушаалтанд тодорхой асуудлыг компанийн нэрийн өмнөөс шийдвэрлэх эрх үүссэн байхын зэрэгцээ удирдлагад хариуцлага хүлээлгэх үндэслэл нь компанийн эрх зүйн зохицуулалтын хувьд удирдлагын хүлээх үүргээ зөрчсөн байх явдал юм. Удирдлагын хүлээх үүргийг Англи, АНУ гэх мэт улсуудад *fiduciary duties* буюу итгэмжлэгдсэн этгээдийн хүлээх үүрэг гэж тодорхойлох нь түгээмэл.⁵⁴

Монгол Улсад Компанийн тухай хуулийн 59.1 дүгээр зүйлд “Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна” гэжээ. Түүнчлэн 75.1 дүгээр зүйлд “Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна” гэсэн байдаг. Түүнчлэн тус хуулийн 83 дугаар зүйлд компанийн гүйцэтгэх удирдлагыг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ гэж заасан. Дээрх заалтуудаас үзэхэд хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал эсвэл гүйцэтгэх удирдлагын баг зэрэг нь компанийн удирдлага юм. Түүнчлэн дээрх заалтаас гадна Компанийн тухай хуулийн 84-р зүйлд “Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно” гэжээ. Тус хуульд удирдлагын хүлээх үүргийг тодорхойлоход компанийн эрх бүхий албан тушаалтан нь компанийн дүрэм, төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал)-ийн баталсан дотоод журамд заасан үүргийг

⁵³ Б.Амарсанаа, Хуулийн этгээдийн удирдлагад хариуцлага хүлээлгэх үндэслэл, Хуулийн этгээдийн эрх зүйн байдал, хариуцлага: Харьцуулсан эрх зүйн асуудал, УБ., 2010, 79 дэх тал.

⁵⁴ Мөн тэнд, 80 дахь тал.

биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллах ёстой гэж заасан байдаг. Энэ нь эрх бүхий албан тушаалтан нь хуулийн этгээдэд нөлөө бүхий, шийдвэр гаргах эрх бүхий этгээд байхыг харуулсан заалт гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, төлөөлөх эрх бүхий байх гэсэн ойлголтод компанийн удирдлагаас гадна эрх бүхий албан тушаалтан багтах боломжтой байна.

Нөхөрлөлийн удирдлага, төлөөллийн тухайд Нөхөрлөлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар гишүүн бүр нөхөрлөлийг удирдах, төлөөлөх эрхтэй. Гэхдээ гэрээнд нөхөрлөлийг удирдах, төлөөлөх эрхийг нэг буюу хэд хэдэн гишүүнд олгохоор зааж болдог.⁵⁵ Удирдах эрх бүхий гишүүд олонхын саналаар хамтран шийдвэр гаргаж, шийдвэртэй холбоотой хариуцлагыг хариуцна гэсэн нь Эрүүгийн хуульд заасан төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтны үйлдэлд хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээнэ гэсэн заалтыг зөрчихгүй байна. Хоршооны тухай хуулиар хоршооны эрх барих байгууллагыг тодорхойлохдоо хоршоо нь бүх гишүүдийн хурал, Тэргүүлэгчид, Хяналтын зөвлөлтэй байна гэжээ.⁵⁶ Хоршооны бүх гишүүдийн хурал нь удирдах дээд байгууллага байх ба гишүүд хоршоонд холбогдох асуудлыг шийдвэрлэх эрхээ бүх гишүүдийн хурлаар дамжуулан хэрэгжүүлнэ.⁵⁷ Түүнчлэн бүх гишүүдийн хурлын чөлөөт цагт хоршооны үйл ажиллагааг Тэргүүлэгчид удирдаж, хоршоог төлөөлөх эрх эдэлдэг. Тэргүүлэгчид нь дарга, хоёр буюу түүнээс дээш гишүүнээс бүрдэх ба Тэргүүлэгчдийн дарга нь хоршооны дарга байна.⁵⁸ Иймд хоршооны удирдлагын тухайд Тэргүүлэгчид, хоршооны дарга, бүх гишүүдийн хурал нь удирдлага буюу төлөөлөх эрх бүхий этгээд байна. Эдгээрээс үзвэл хуулийн этгээд бүрийн төлөөлөх эрх бүхий этгээд нь тус тус хуулиар янз бүрээр тодорхойлогдох боломжтой байгааг харж болно. Түүнчлэн хуулийн этгээдийн удирдах байгууллагын бүрэн эрхийг хуулиар тодорхойлсон байдгаас гадна хуулиар зохицуулагдаагүй асуудлыг үүсгэн байгуулах баримт бичгээр тодорхойлно. Тухайлбал, Төрийн бус байгууллагын тухай хуульд зааснаар удирдах дээд

⁵⁵ Нөхөрлөлийн тухай хууль, 1995, 21 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг.
www.legalinfo.mn

⁵⁶ Хоршооны тухай хууль, 1998, 22 дугаар зүйл, 22.1 дэх хэсэг.

⁵⁷ Мөн тэнд. 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг.

⁵⁸ Мөн тэнд. 27 дугаар зүйлийн 27.1, 2, 3 дахь хэсэг.

байгууллага нь гишүүдийн хурал байж болох боловч тухайн хуулийн этгээдийн дүрэмд заасан бол удирдах дээд байгууллага нь удирдах зөвлөл байж болно гэжээ.⁵⁹ Энэ тохиолдолд удирдах зөвлөлийн бүрэн эрхийг уг байгууллагын дүрэмд зааснаар тодорхойлно гэсэн үг юм. Түүнчлэн итгэмжлэлээр хуулийн этгээдийг төлөөлөх эрх олгох ба энэ нь өмгөөлөгч, компанийн бусад ажилтан байх нь бий. Иймд эрх зүйн харилцаанд буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг шүүхэд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээд нь төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдүүд байх боломжтой гэж үзэж байна. Харин зарим орны эрүүгийн эрх зүйн зохицуулалтад өмгөөлөгч болон бусад этгээдэд итгэмжлэл олгох замаар хуулийн этгээдийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлүүлж болдог байна.⁶⁰

2.1.3. Хуулийн этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлагын төрөл

2015 оны Эрүүгийн хуульд “хуулийн этгээдэд ял оногдуулах” гэж хуульчилсан байсныг 2017 оны нэмэлт өөрчлөлтөөр “хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах” болгон өөрчлөн найруулж, тус хуулийн үзэл баримтлалд “Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд “эрүүгийн хариуцлага” гэх нэр томъёог хасаж, үүний оронд “ял, албадлагын арга хэмжээ” гэх эрүүгийн хариуцлагын бие даасан хоёр институцийг тус тусад нь тодорхойлсон нь эрүүгийн эрх зүйн нийтлэг зарчимд нийцээгүй, эдгээрийг харилцан уялдаатай нэг зорилтын дор хэрэгжүүлэхэд хүндрэл учруулахаар байх тул эрүүгийн хариуцлага гэх ойлголтыг нэмж, үүнд ял, албадлагын арга хэмжээг хамруулахаар тусгасан”⁶¹ гэжээ. Хуулийн үзэл баримтлалаас харахад эрүүгийн хариуцлага гэсэн ойлголтод ял, албадлагын арга хэмжээг хамтад нь ойлгож хэрэглэхээр хуульчилсан нь харагдаж байна.

⁵⁹ Төрийн бус байгууллагын тухай хуулийн 11 дүгээр зүйл.

⁶⁰ https://docs.google.com/file/d/1fwVz_US6sXKX сүүлд зочилсон 2018.11.30.

⁶¹ <http://mojha.gov.mn/images/files/huuliintusul/taniltsuulga-eruu-20161111.pdf>

2015 оны Эрүүгийн хууль батлагдан гарахдаа торгох, эрх хасах, татан буулгах гэсэн гурван төрлийн ял оногдуулахаар заасан байсныг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр зөвхөн торгох ял оногдуулахаар өөрчилж, эрүүгийн хариуцлагын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд оногдуулсан ял дээр нэмж дараах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно⁶² гээд (i) эрх хасах албадлагын арга хэмжээ; (ii) татан буулгах албадлагын арга хэмжээ; (iii) хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ оногдуулахаар заасан.

Эрүүгийн хуулиар хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэж буй 31 гэмт хэргийг ял шийтгэлийн төрлөөр нь ангилан авч үзэхэд зөвхөн торгох ял оногдуулах есөн зүйл, торгох ял, эрх хасах арга хэмжээ оногдуулах 19 зүйл, татан буулгах албадлагын арга хэмжээ хэрэглэх хоёр зүйл байгаа нь хуулийн этгээдэд торгох ялыг эрх хасах албадлагын арга хэмжээтэй хамт хэрэглэх санкц түгээмэл байгааг харуулж байна.

Торгох ял. Монгол Улсын Эрүүгийн хуулиар хувь хүнд 100,000-40,000,000 төгрөгийн торгох ял, хуулийн этгээдэд 10,000,000-400,000,000 төгрөгийн торгох ял оногдуулж байна.⁶³ Хуулийн этгээдэд оногдуулах торгох ялын тухайд олон улсад түгээмэл баримталдаг зарчмын нэг нь хувь хүнд оногдуулж байгаа торгох ялын хэмжээнээс хэд дахин их байх тухай юм. Эрүүгийн хуулиар тогтоосон хэмжээгээр хуулийн этгээдэд оногдуулж буй торгох ялын дээд, доод хэмжээ нь хувь хүнд хүлээлгэж байгаагаас арав дахин их байгаа нь дэлхий нийтийн зарчмыг хангаж байна. Хуулийн этгээдэд оногдуулах торгох ялын хоёр дахь онцлог нь ялын хэмжээ нь тухайн хуулийн этгээдэд тохирсон уян хатан байх явдал юм. Эрүүгийн хуульд 10,000-400,000 нэгжтэй тэнцэх хэмжээний торгууль оногдуулахаар хамгийн олон зүйлд хуульчилсан нь ялын уян хатан байдлыг хангах боломжтой харагдаж байна. Торгох ялын үр нөлөө нь торгуулийн хэмжээ тэдэнд “хүнд цохилт” болохоор буюу гэмт хэрэг үйлдээд олсон орлогоос нь

⁶² Эрүүгийн хуулийн 9.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, “Төрийн мэдээлэл”, 2016, №7.

⁶³ Эрүүгийн хуулийн 5.3 дугаар зүйлд “Торгох ялын хэмжээ нь нэг зуун нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна” гэж, 9.3 дугаар зүйлд “1. Энэ хуульд заасан тохиолдолд арван мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр хуулийн этгээдэд торгох ял оногдуулна” гэж тус тус заасан. “Төрийн мэдээлэл”, 2016, №7.

хэд дахин илүү байж ач холбогдолтой болно. Монгол Улсад хуулийн этгээдэд захиргааны хариуцлагын арга хэмжээ болох торгуулийн шийтгэл оногдуулж байсан хэдий ч тэрхүү арга хэмжээ үр нөлөөгүй байсан нь түүний торгуулийн хэмжээ хэт доогуур байсантай холбоотой гэж судлаачид үздэг.

Тухайлбал, химийн хорт бодис ашиглан ашигт малтмал олборлодог компанийн сарын ашиг нь 500 сая төгрөг гэж тооцоход шүүхээс түүнд 10-400 сая төгрөгийн торгох ял оногдуулахад үр нөлөөгүй юм. Энэ тохиолдолд компани хууль бус үйл ажиллагаагаа үргэлжлүүлсээр байх боломжтой. Ер нь дэлхийн улс орнуудад хуулийн этгээдэд торгууль оногдуулахдаа дараах хэдэн хүчин зүйлийг харгалзан үзэх нь бий. Үүнд, гэмт хэргийн хэр хэмжээ, мөрдөх ёстой стандартаас хэдий хэмжээгээр зөрсөн, эрсдэлийн зэрэг, хор аюулын хэмжээ, гэм буруугийн хэлбэр, гэмт хэргийг давтан үйлдсэн эсэх, гэмт хэрэгтэн-хуулийн этгээдийн хөрөнгө нөөцийн хэмжээ, хуулийн этгээдийн цаашдын үйл ажиллагаанд үзүүлэх сөрөг үр нөлөө зэрэг юм.⁶⁴

Эрүүгийн хуульд заасан торгох ялыг хэмжээгээр нь ангилан үзвэл таван түвшинд хуваагдана. Үүнд, 10,000-80,000, 20,000-120,000, 40,000-200,000, 120,000-400,000, 200,000-400,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна. Гэмт хэргийн хохирол, хор уршиг, нийгэмд аюултай байдал, гэмт хэргийн цар хүрээ зэрэг олон нөхцөл байдлыг харгалзан үзэж Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 31 төрлийн гэмт хэрэгт дараах байдлаар торгох ялыг ялгамжтай оногдуулахаар хуульчилсан.

Монгол Улсын Эрүүгийн хуульд хуулийн этгээдийг торгох ялын хэмжээ 10-80 сая, 40-120 сая, 200-400 сая гэх мэтээр дээд, доод хэмжээний интервал их ялгаатай байгаа нь шүүгч торгох ялыг тухайн хуулийн этгээдийн нөхцөл байдлыг харгалзан ялгамжтай оногдуулах боломж олгосон заалт болжээ. Иймд шүүх торгох ял оногдуулахдаа ялын доод, дээд интервалын хэмжээг хуулийн этгээдэд ашигтай байдлаар буюу хуулийн этгээдийн хөрөнгийн хэмжээ, ял даах байдал, бизнесийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхэд үзүүлэх үр нөлөө зэргийг харгалзан хэрэглэхийн зэрэгцээ мэдээж, ялын үр нөлөөтэй байх явдал, тухайн

⁶⁴ “Эрүүгийн эрх зүйн шинэтгэл: Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ., 2017, 38 дахь тал.

гэмт хэргийн нийгмийн хор аюул, гэмт хэргийн хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэр, давтан үйлдсэн эсэх зэргийг анхааран үзэх нь зүйтэй.

2.1.4. Эрүүгийн хариуцлага оногдуулах гэмт хэргийн төрөл

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын анхны төсөл 2013 онд хийгдэж УИХ-д өргөн баригдахад 80 гаруй зүйл, заалтуудаар хуулийн этгээдэд ял оногдуулахаар заасан байна. Энэ нь 2015 онд батлагдахдаа 50 орчим болж цөөрсөн бол шинэ Засгийн газар 40 орчимд багцалж оруулсан байсан нь 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр 31 зүйл болж буурсан.⁶⁵

Дэлгэрүүлэн авч үзвэл 2015 оны Эрүүгийн хуулийн 41 зүйлд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь 15.5 дугаар зүйлийн Хууль бусаар үр хөндөх, Эдийн засгийн гэмт хэрэг гэсэн бүлгийн 18.1-18.10, 13 гэсэн 12 зүйл, Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг гэсэн бүлгийн 20.4 -20.14 дүгээр зүйлийн 10 зүйл, Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг гэсэн бүлгийн 21.7, 21.8, 22.5 дугаар зүйл, Хахууль өгөх гэмт хэрэг, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг гэсэн бүлгийн 24.1-24.9 хүртэлх найман зүйл, Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг бүлгийн 25.2, 3, 5 дугаар зүйлд заасан гурван зүйл, 27.9 дугаар зүйлд заасан Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих гэмт хэрэг, 29.3-29.11 дүгээр зүйлийн таван зүйлд заасан гэмт хэрэг зэрэг байна.⁶⁶

2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 11 зүйлийг хүчингүй болгож 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэсэн зүйлийг нэмж хуульчлан 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар Монгол Улсын Эрүүгийн хуульд 31 гэмт хэрэгт хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан.

⁶⁵ “Эрүүгийн эрх зүйн шинэтгэл: Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ., 2017, 7 дахь тал.


⁶⁶ Эрүүгийн хууль 2015 он, Төрийн мэдээлэл 2016, №7

Эдгээрийг бүлэг, зүйлээр нь ангилан, дэлгэрүүлж авч үзвэл Эрүүгийн хуулийн 10-29 дүгээр бүлэг хүртэл нийт 19 бүлэг гэмт хэргийн долоод буюу 36.8 хувьд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа хэдий ч зүйлээр нь авч үзвэл энэ нь маш бага хувийг эзэлж байна. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй гэмт хэргийг Эрүүгийн хуулийн бүлэг, зүйлээр ангилан үзвэл:

1. Эдийн засгийн гэмт хэрэг буюу Эрүүгийн хуулийн 18 дугаар бүлэг – 10;
2. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг буюу 24 дүгээр бүлэг – 6;
3. Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг буюу 20 дугаар бүлэг – 6 (Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар ашиглах, чанар муутай барилга байшин ашиглалтад оруулах, эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах, түгээх гэх мэт гэмт хэрэг багтана);
4. Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг буюу 29 дүгээр бүлэг – 5;
5. Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг буюу 25 дугаар бүлэг – 2;
6. Авлигын гэмт хэрэг буюу 22 дугаар бүлэг – 1;
7. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг-1 байна.

Үүнийг График 1-д задлан харуулав.

График 1. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй гэмт хэргийн төрөл



Эрүүгийн хуулийн дээрх гэмт хэргийн төрлийг Зөрчлийн тухай хуультай харьцуулсан үзүүлэлтийг Хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1. Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулийн харьцуулалт

№	Эрүүгийн хууль	Зөрчлийн тухай хууль
1	18.1 дүгээр зүйл. Зах зээл дэх монопол, давамгайл байдлаа хууль бусаар ашиглах	10.7 дугаар зүйл. Өрсөлдөөний тухай хууль зөрчих
2	18.5 дугаар зүйл. Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх	11.21 дүгээр зүйл. Гаалийн тухай хууль зөрчих
3	18.6 дугаар зүйл. Мөнгө угаах	11.29 дүгээр зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль зөрчих
4	18.8 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн дотоод мэдээллийг хууль бусаар ашиглах	11.10 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль зөрчих

Хүснэгт 1-ийн үргэлжлэл

5	18.9 дүгээр зүйл. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах.	11.10 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль зөрчих
6	18.13 дугаар зүйл. Банк хууль бусаар байгуулах, банкны төлбөрийн чадвар алдагдуулах	11.3 дугаар зүйл. Банкны тухай хууль зөрчих
7	20.7 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	6.4 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих
8	20.11 дүгээр зүйл. Аюултай хог хаягдал, химийн хорт, аюултай бодисыг хаях	6.1 дүгээр зүйл. Хог хаягдлын тухай хууль зөрчих
9	20.12 дугаар зүйл. Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах, түгээх	6.15 дугаар зүйл. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль зөрчих
10	20.13 дугаар зүйл. Чанар муутай барилга байгууламж ашиглалтад оруулах	12.1 дүгээр зүйл. Барилгын тухай хууль зөрчих
11	20.14 дүгээр зүйл. Хууль бусаар эм, био бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх	6.6 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль зөрчих
12	24.2 дугаар зүйл. Хууль бусаар ашигт малтмал хайж, ашиглах, олборлох	7.11 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хууль зөрчих
13	24.3 дугаар зүйл. Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах	5.11 дүгээр зүйл. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль зөрчих
14	24.4 дүгээр зүйл. Цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийг хууль бус эргэлтэд оруулах	12.11 дүгээр зүйл. Цөмийн энергийн тухай хууль зөрчих

Хүснэгт 1-ийн үргэлжлэл

15	24.6 дугаар зүйл. Хууль бусаар мод бэлтгэх	7.9 дүгээр зүйл. Ойн тухай хууль зөрчих
16	25.2 дугаар зүйл. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах	9.7 дугаар зүйл. Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих
17	27.9 дүгээр зүйл. Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих	14.5 дугаар зүйл. Авто зам, замын байгууламж, тэмдэг тэмдэглэлийг гэмтээх, өөрчлөх, бохирдуулах
18	29.3 дугаар зүйл. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх	5.10 дугаар зүйл. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль зөрчих
19	29.10 дугаар зүйл. Террор үйлдэхийг санхүүжүүлэх	11.29 дүгээр зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль

Дээрх 19 төрлийн гэмт хэрэг, зөрчил Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд хэрхэн ялгамжтай тусгагдсаныг, мөн бусад онцлогийг харьцуулан үзэхэд дараах хэдэн шинж харагдаж байна. Үүнд:

1. Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг нь өөр хуулиас иш татсан заалтгүй бол Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлүүд нь өөр хууль, журмыг зөрчсөн бол гэж иш татсан диспозицтой байх нь элбэг байна. Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 11.29 дүгээр зүйлд “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд зааснаар”, 12.1 дүгээр зүйлд “Барилгын тухай хуульд зааснаар” гэх мэт.
2. Эрүүгийн хуулиар гэмт хэрэг үйлдэх субъектийг тусгайлан заадаггүй бол Зөрчлийн тухай хуулиар ихэвчлэн субъект нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл, тухайн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл авсан этгээд тэрхүү зөвшөөрөл авсан цар хүрээнээсээ хэтрүүлэн хийсэн үйлдэл байхаар тусжээ. Жишээ

нь, Эрүүгийн хуулийн 201.12 дугаар зүйлд заасан Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах, түгээх гэмт хэргийн тухайд ямар ч төрлийн хуулийн этгээд байж болох бол Зөрчлийн тухай хуулийн 6.15 дугаар зүйлд заасан хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль зөрчих зөрчлийн субъект нь хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд байна. Түүнчлэн Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлд заасан хууль бусаар ашигт малтмал хайж, ашиглах, олборлох гэмт хэргийн тухайд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт, ашиглалт явуулсан эсхүл ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар хууль бусаар газрын хэвлийд халдсан этгээд нь тусгай субъект байдаггүй бол Зөрчлийн тухай хуулийн 7.11 дүгээр зүйлд ашигт малтмалын тухай хууль зөрчих зөрчлийн субъект нь тусгай зөвшөөрөл эзэмшигч байхаар хуульд заажээ.

3. Гэмт хэрэг, зөрчлийг ялгаж хуульчилсан нэг онцлог шинж нь хуулийн этгээдийн зүгээс учруулсан хохирол, хор уршгийн хэмжээ, нийгэмд аюултай байдлын зэрэг байна. Эрүүгийн хуульд хүний эрүүл мэндэд хүндэвтэр, хүнд хохирол учруулсан, хүний амь нас хохирсон, энэ үйлдлийн улмаас үлэмж, их хэмжээний хохирол учирсан бол гэмт хэрэг гэж тооцохоор хуульчилсан нь түгээмэл харагдаж байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 20.13 дугаар зүйлийн “Чанар муутай барилга байгууламж ашиглалтад оруулах гэмт хэрэг”-ийг “Чанар муутай барилга байгууламж барьсан, бариулсан, ашиглалтад оруулсны улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хүний амь нас хохирсон, эд хөрөнгөд их хэмжээний хохирол учирсан бол” гэж зүйлчилсэн бол Зөрчлийн тухай хуулийн 12.1 дүгээр зүйлийн “Барилгын тухай хуульд заасан барилгын үйл ажиллагаанд заавал эсхүл сонгож мөрдөх барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг дагаж мөрдөөгүй, ...барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэсэн, ...бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн заалтад хохирлын хэмжээг тусгаагүй байна.

Эрүүгийн хуулийн 18.1 дүгээр зүйлд заасан “Зах зээл дэх монопол, давамгайл байдлаа хууль бусаар ашиглах” гэмт хэргийг Зөрчлийн тухай хуулийн 10.7 дугаар зүйлээс ялгах нэг онцлог нь хуулийн этгээд, аж ахуй эрхлэгч нь зах зээл дэх монопол байдлаа ашиглан хуулиар хориглосон ноёлох үйл ажиллагаа явуулснаас бусдад их хэмжээний хохирол буюу 50,000 нэгжтэй тэнцэх хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг гэж үзэх ба үүнээс бага хохирол учруулсан бол Зөрчлийн тухай хуулиар торгох шийтгэл оногдуулахаар зохицуулжээ.

4. Дөрөв дэх гол ялгаа нь хуулийн этгээдэд оногдуулж буй ял, шийтгэлийн хэмжээ байна. Эрүүгийн хуулиар хуулийн этгээдэд 10,000,000-400,000,000 төгрөгийн торгох ял оногдуулж байгаа бол Зөрчлийн тухай хуулиар 100,000-200,000,000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулдаг. Эрүүгийн хуулиар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулж буй нийт 31 гэмт хэргийн тухайд 10,000-80,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр найм, 20,000-120,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр найм, 40,000-200,000,000 төгрөгөөр гурав, 120,000,000-400,000,000 сая төгрөгөөр ес, 200,000,000-400,000,000 төгрөгөөр гурван гэмт хэрэгт торгох ял оногдуулахаар заасан. Харин Зөрчлийн тухай хуулиар 200 нэгжээр 26, 300 нэгжээр 35, 500 нэгжээр 106, 1,000 нэгжээр 84, 1,500 нэгжээр гурав, 4,000 нэгжээр нэг, 5,000 нэгжээр нэг, 10,000 нэгжээр 71, 20,000 нэгжээр 42, 30,000 нэгжээр 12, 40,000 нэгжээр 14, 50,000 нэгжээр 15, 70,000 нэгжээр нэг, 80,000 нэгжээр нэг, 100,000 нэгжээр ес, 200,000 нэгжээр таван зүйл, хэсэгт тус тус торгох шийтгэл оногдуулахаар заажээ. Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд давхардаж хуульчлагдсан 19 гэмт хэрэг, зөрчлийн тухайд үзэхэд 14 гэмт хэрэг буюу 73 хувьд торгох ял нь зөрчилд оногдуулж буй шийтгэлийн хэмжээнээс дунджаар 10 дахин их хэмжээтэй байна. Зөрчлийн тухай хуулиар оногдуулж буй хамгийн өндөр шийтгэл нь 200,000 нэгжтэй тэнцэх буюу 200 сая төгрөгийн торгуулийг 5.10 дугаар зүйлд заасан “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль зөрчих” зөрчилд

оногдуулж байгаа нь Эрүүгийн хуульд заасан 120,000,000-400,000,000 төгрөгийн торгох ялтай дүйцэж болохоор өндөр хэмжээтэй байна. Түүнчлэн Эрүүгийн хуульд заасан үлдсэн гурван гэмт хэргийн хувьд 10,000,000-80,000,000 төгрөгийн торгох ял оногдуулах бол тэдгээрийн зөрчилд 20,000,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар байна. Мөн Зөрчлийн тухай хуулийн 11.3 дугаар зүйлд “Банкны үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүй эрхэлсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хуулийн этгээдийг **нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр** торгоно” гэснийг Эрүүгийн хуулийн 18.13 дугаар зүйлийн Банк хууль бусаар байгуулах, банкны төлбөрийн чадвар алдагдуулах гэсэн зүйлд заасан “Банкийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр нээж үйл ажиллагаа явуулсан, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг хууль бусаар бүрдүүлсэн бол ...хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж **арван мянган нэгжээс наян мянган нэгжээр торгох** ял шийтгэнэ” гэсэн заалттай харьцуулан үзэхэд Эрүүгийн хуулийн торгох ял, зөрчилд оногдуулж буй захиргааны хариуцлагын торгох шийтгэлээс бага хэмжээтэй байгаа нь ялын үр нөлөөг алдагдуулсан, алдаатай зохицуулалт болжээ.

5. Хууль тогтоогч зөрчлийн тухай хуулийн хэм хэмжээг тогтоохдоо хэм хэмжээний давхардал үүсгэхгүйн үүднээс “эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол” хэмээн заажээ. Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, бүртгэх, тайлагнах журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол”, түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйл буюу “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль зөрчих” гэсэн зүйл “Үнэт цаасны зах зээлд оролцогч, харилцагчийг хууран мэхлэх замаар арилжаанд оролцуулсан эсхүл оролцуулахгүй байх эсхүл бусад арга хэлбэрээр үнэт цаасны зах зээлийг урвуулан ашигласан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол...” гэжээ.

Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд давхар хуульчилсан дээрх гэмт үйлдлүүдийг ялган зүйлчлэх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хуульчдыг төөрөгдүүлэх нөхцөл байдал бий болгожээ. Иймд дээрх хоёр хуулийн эрх зүйн зохицуулалтыг нэг мөр ойлгох, боловсронгуй болгох нь хуулийг буруу тайлбарлаж хэрэглэх, ял завших, хуулийн хийдэл үүсэх зэрэг эрх зүйн сөрөг үр дагавраас сэргийлнэ.

2.2. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА: БҮГД НАЙРАМДАХ ЭСТОНИ УЛС, БҮГД НАЙРАМДАХ СОЦИАЛИСТ ВЬЕТНАМ УЛС

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа дэлхийн 50 гаруй улс байдаг. Эдгээр улс эрх зүйн тогтолцооныхоо онцлог, хэв маягт тохируулан онолын гурван загвараас сонгон авч хуульчилж байгаагаас эрх зүйн тогтолцоо, эрх зүйн хөгжлийн онцлог болон хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулж байгаа туршлагаараа ойролцоо Бүгд Найрамдах Эстони Улс (цаашид Эстони Улс гэх), Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс (цаашид Вьетнам Улс гэх)-ыг сонгон авч эрх зүйн зохицуулалтыг нь судалж харьцууллаа. Ийнхүү харьцуулахдаа дээрх хоёр улсын хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй үндэслэл, давхар хариуцлагын зарчим, эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй гэмт хэргийн төрөл, хүлээлгэж байгаа ял, хариуцлагын төрөл, хэмжээг судлав.

Вьетнам Улсын 2015 оны Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлгийн 225 болон 226 дугаар зүйлд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар анх удаа зохицуулан, энэхүү хуулийн заалт нь 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болж хэрэгжиж эхэлжээ. Хуулийн заалт хэрэгжиж эхэлснээс хойш 2020 оны нэгдүгээр сард тус улсын шүүх оюуны өмчийн гэмт хэрэгт анх удаа компанид эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн.⁶⁷ Тус улсын Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлд гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд Эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх тухай заахын зэрэгцээ хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөл нь дараах үндэслэл болно⁶⁸ гэжээ. Үүнд:

⁶⁷ Corporate Criminal Liability Gets First Test in Vietnam for IP Crimes.
<https://www.lexology.com/library/detail.aspx?g=df52801d-2de9-4fed-afe4-a706bba9b05d>

⁶⁸ Вьетнамын Эрүүгийн хуулийн 75 дугаар зүйл.

- а. Гэмт хэргийг хуулийн этгээдийн нэр дээр үйлдсэн;
- б. Гэмт хэргийг хуулийн этгээдийн ашиг сонирхлын үүднээс үйлдсэн;
- в. Гэмт хэргийг хуулийн этгээдийн зөвшөөрлөөр эсвэл зааварчилгааны дагуу үйлдсэн;
- г. Тус хуулийн 27 дугаар зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацааны дотор үйлдсэн.

Дээрх үндэслэл нь Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан үндэслэлтэй давхцаж байгаа бөгөөд харин “хөөн хэлэлцэх хугацааны дотор үйлдсэн байх” гэсэн нөхцөл нь манай улсынхаас ялгаатай байна.

Эстони Улсын Эрүүгийн хуулийн 14 дүгээр зүйлд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг “Хуульд заасан тохиолдолд хуулийн этгээд нь хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд эсвэл ахлах ажилтан хамтран, ганцаараа хийсэн үйлдлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээнэ” гэсэн нь мөн л манай улсад хуульчилсан гурван үндэслэлийг агуулжээ.

Эстонийн Эрүүгийн хуульд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь хувь хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд саад учруулахгүй хэмээн давхар хариуцлагын зарчмыг хүлээн зөвшөөрсөн. Мөн Вьетнам Улсын Эрүүгийн хуульд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь хувь хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй гэж⁶⁹ Азийн улсуудын нэгэн адил давхар хариуцлагын тогтолцоог хуульчилсан байна.

Дараагийн нэг асуудал бол хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй гэмт хэргийн төрөл юм. Вьетнам Улсын Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх цар хүрээ буюу гэмт хэргийн төрлийг заасан. Үүнд, Хууль бусаар барааг хил нэвтрүүлэх (188 дугаар зүйл), Хил давуулан хууль бусаар бараа, мөнгө нэвтрүүлэх (189 дугаар зүйл), Хууль бус бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдах (190 дүгээр зүйл), Хууль бус бараа бүтээгдэхүүн хадгалах, тээвэрлэх (191 дүгээр зүйл), Эм хуурамчаар

⁶⁹ Вьетнамын Эрүүгийн хуулийн 75 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

үйлдвэрлэх, худалдах (194 дүгээр зүйл), Амьтны тэжээл, бордоо, ургамлын төрөл зүйл, амьтны үүлдэр зэргийг хуурамчаар үйлдвэрлэх, худалдах (195 дугаар зүйл), Барааны нөөц хэт ихэсгэх (196 дугаар зүйл), Татвараас зайлсхийх (200 дугаар зүйл), Төлбөрийн баримт, нэхэмжлэлийг хууль бусаар хэвлэх, олгох, худалдах (203 дугаар зүйл), Хөрөнгийн зах зээл дэх мэдээллийг нуун дарагдуулах болон буруу мэдээлэл нийтэд түгээх (209 дугаар зүйл), Хөрөнгийн зах зээл дэх дотоод мэдээллийг ашиглах (210 дугаар зүйл), Үнэт цаасны зах зээлийг төөрөгдүүлэх (211 дугаар зүйл), Даатгалын үйл ажиллагаанд залилах (213 дугаар зүйл), Ажилтан нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал болон ажилгүйдлийн даатгалын төлбөрөөс зайлсхийх (216 дугаар зүйл), Өрсөлдөөний хууль тогтоомж зөрчих (217 дугаар зүйл), Зохиогчийн эрх зөрчих (225 дугаар зүйл), Үйлдвэрийн оюуны өмчийн эрх зөрчих (226 дугаар зүйл), Байгалийн баялгийг судлах, хайгуул хийх, олборлох журам зөрчих (227 дугаар зүйл), Ойн олборлох, хамгаалах журам зөрчих (232 дугаар зүйл), Ан амьтдыг хамгаалах журам зөрчих (234 дугаар зүйл), Байгалийн бохирдол бий болгох (235 дугаар зүйл), Байгаль орчны гэнэтийн ослоос хамгаалах, хариу үйлдэл үзүүлэх, тусламж үзүүлэх журам зөрчих (237 дугаар зүйл), Байгалийн гамшигт үзэгдэл, усжуулалт, далан зэргийн журам зөрчих (238 дугаар зүйл), Вьетнам Улсын хилээр хог хаягдал оруулах (239 дугаар зүйл), Усан баялгийг устгах (242 дугаар зүйл), Ой устгах (243 дугаар зүйл), Аюулд орсон болон ховор амьтдыг хамгаалах журам зөрчих (244 дүгээр зүйл), Дархан цаазат газрын ашиглалтын журам зөрчих (245 дугаар зүйл) зэрэг 30-аад гэмт хэргийг жагсаажээ.

Харин Эстони Улсын Эрүүгийн хуулиар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах гэмт хэрэг нь 2002 оноос хойш нэмэгдсээр одоогийн байдлаар тусгай ангийн 133 гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага оногдуулахаар заажээ. Тухайлбал, байгаль орчин бохирдуулах, дотоод мэдээлэл арилжих, татвараас зайлсхийх, залилан, хээл хахууль өгөх, далайн дээрэм, дайныг ухуулах, хүүхэд худалдах, терроризмын гэмт хэргүүдийг дурдаж болно.

Монгол Улсын Эрүүгийн хуулиар 31 төрлийн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа нь Вьетнам Улстай харьцуулахад ойролцоо тоотой байгаа ч Эстони Улсынхтай харьцуулахад нэлээд цөөн байгаа

нь харагдаж байна. Цаашид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах гэмт хэргийн төрлийг олшруулах шаардлагатай эсэхийг судлан үзэх нь зүйтэй.

Вьетнам Улсын Эрүүгийн хуулиар хуулийн этгээдэд торгох ялыг үндсэн болон нэмэгдэл байдлаар оногдуулдаг.⁷⁰ Торгуулийн хэмжээг тогтоохдоо гэмт хэргийн үндсэн шинж, нийгмийн аюулын түвшнээс хамаарах төдийгүй хуулийн этгээдийн санхүүгийн чадамж, үнэ ханшны хэлбэлзлийг тооцоолдог байна.⁷¹ Хэдий тийм боловч торгууль 50,000,000 VND-оос доош байж болохгүй. Энэ нь 2,168\$ буюу 6,176,762 төгрөгтэй тэнцэнэ.⁷² Түүнчлэн Эрүүгийн хуулиар үйл ажиллагааг нь зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зогсоох⁷³ мөн татан буулгах арга хэмжээ авч болдог.⁷⁴ Үүний зэрэгцээ Вьетнам Улсын Эрүүгийн хуулиар хуулийн этгээдийн тодорхой салбар дахь үйл ажиллагааг хориглох, хуулийн этгээдийн хөрөнгийг өсгөх үйл ажиллагааг хориглох (1-3 жилийн хугацаанд) зэрэг шийтгэлийг шүүх оногдуулж болдог байна.⁷⁵ Вьетнам Улсад хуулийн этгээдэд торгох ялаас гадна үндсэн хөрөнгийг албадан сэргээх, хор уршгаас урьдчилан сэргийлэх, хөнгөрүүлэх арга хэмжээг албадан гүйцэтгэх зэрэг албадлагын арга хэмжээ оногдуулдаг.⁷⁶

Эстони Улсын Эрүүгийн хуулиар хуулийн этгээдэд мөнгөн торгууль болон албадан татан буулгах гэсэн хоёр төрлийн ял оногдуулдаг.⁷⁷ Торгох ял нь 50,000-аас 50 сая крон буюу 3,000-аас 16 сая еврогийн хэмжээтэй.⁷⁸ Торгохыг татан буулгах ял дээр нэмж нэмэгдэл ялын шинжтэй оногдуулж болдог. Шүүхээс хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг нь түүний үйл ажиллагааны нэг хэлбэр болсон тохиолдолд татан буулгах ял оногдуулдаг байна.

⁷⁰ Вьетнам Улсын Эрүүгийн хуулийн 77 дугаар зүйл. 1 дэх хэсэг.

⁷¹ Мөн тэнд 2 дахь хэсэг.

⁷² www.mongolbank.mn

⁷³ Вьетнам Улсын Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйл.

⁷⁴ Вьетнам Улсын Эрүүгийн хуулийн 79 дүгээр зүйл.

⁷⁵ Вьетнам Улсын Эрүүгийн хуулийн 80 болон 81 дүгээр зүйл.

⁷⁶ Вьетнам Улсын Эрүүгийн хуулийн 82 дугаар зүйл.

⁷⁷ Эстони Улсын Эрүүгийн хуулийн 44 болон 46 дугаар зүйл.

⁷⁸ Jaan Ginter, *Criminal Liability of Legal Persons in Estonia*, JURIDICA INTERNATIONAL XVI, 2009.

ГУРАВ. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

3.1. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ (2017-2021 ОНЫ 6 ДУГААР САР)

Монгол Улсад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй өнөөгийн нөхцөлийг тодруулах зорилгоор цагдаа, прокурор, шүүхийн байгууллагын 2017-2021 оны хагас жилийн тоон мэдээнд дүн шинжилгээ хийлээ.

2017 оны 7 дугаар сарын 1-нээс Эрүүгийн хуулийн есдүгээр бүлэгт зааснаар хуулийн этгээдэд 31 төрлийн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх болсон. Прокурорын байгууллагын дүн мэдээнд нийт дөрвөн жилийн хугацаанд улсын хэмжээнд 27 гэмт хэрэг бүртгэгдсэн байна (Хүснэгт 2-ыг харна уу).

*Хүснэгт 2. УЕПГ-аас гаргасан хуулийн этгээдийн
эрүүгийн хариуцлагын тоон мэдээ
(2017-2021 оны эхний хагас жилийн байдлаар)*

№	Хаана	Огноо	Зүйл, анги	Яллагдагч	Шийдвэр
1	Өвөрхангай	2017	27.9-2 27.9 дүгээр зүйл. Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих	“ИБ” ХХК	Шүүхэд шилжсэн.

Хүснэгт 2-ын үргэлжлэл

2	Баянхонгор	2017	24.2-3 Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	“ХЛ” ХХК	Шүүхэд шилжсэн.
3	Баянхонгор	2017	24.2-3 Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	“З” ХХК	Шүүхэд шилжсэн.
4	Нийслэл	2017	22.5-3 Хахууль өгөх	“ЗОЛ” ХХК	Шүүхээр эцэслэн шийдсэн.
5	Баянхонгор	2017	24.2.3 Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	“ОБТ” ХХК	Шүүхээр эцэслэн шийдсэн.
6	Баянхонгор	2017	24.2-1 Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	“ХШ” ХХК	Хэрэг- сэхгүй болгосон.
7	Сүхбаатар дүүрэг	2017	20.14-1 Хууль бусаар эм, био бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх	“ЦГ” ХХК	Түдгэл- зүүлсэн.
8	Нийслэлийн Прокурорын газар	2017	18.5-5 Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх	“ААТ” ХХК	Ажилла- гаанд байгаа.

Хүснэгт 2-ын үргэлжлэл

9	Өмнөговь-Ханбогд	2018	24.6-3 Хууль бусаар мод бэлтгэх	“ГТЛ” ХХК	Хэрэг бүртгэлийн хэргийг хаасан.
10	Сэлэнгэ	2018	24.6-1 Хууль бусаар мод бэлтгэх	“ХБ” ХХК	Хэрэгсэхгүй болгосон.
11	Нийслэлийн Прокурорын газар	2018	24.3-3 Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах	“Ж” ХХК	Шүүхээр эцэслэн шийдсэн.
12	Баянхонгор	2018	24.2-3 Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	“Ж” ХХК	Хэрэгсэхгүй болгосон.
13	Баянхонгор	2018	24.2-3 Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	“СХ” ХХК	Шүүхээр эцэслэн шийдсэн.
14	Нийслэлийн Прокурорын газар	2019	22.5-3 Хахууль өгөх	“ЧХБ” ХХК	Шүүхээр эцэслэн шийдсэн.
15	Нийслэлийн Прокурорын газар	2019	24.6-3 Хууль бусаар мод бэлтгэх	“ЦА” ХХК	Шүүхээр эцэслэн шийдсэн.
16	Нийслэлийн Прокурорын газар	2019	22.5-3 Хахууль өгөх	“ЕШ” ХХК	Ажиллагаанд байгаа.

Хүснэгт 2-ын үргэлжлэл

17	Өмнөговь	2019	27.9-2 Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих	“Д” ХХК	Шүүхээр эцэслэн шийдсэн.
18	Баянхонгор	2019	24.2-3 Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	“ӨТО” ХХК	Шүүхэд шилжсэн.
19	Нийслэлийн Прокурорын газар	2019	24.3-3 Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах	“ЦШ” ХХК	Хэрэг-сэхгүй болгосон.
20	Орхон	2019	22.5-1 Хахууль өгөх	“ОД” ХХК	Ажиллагаанд байгаа.
21	Сонгино-хайрхан дүүрэг	2019	11.5-1 Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах	“ХИ” ХХК	Ажиллагаанд байгаа.
22	Чингэлтэй дүүрэг	2020	20.14 дүгээр зүйл 1, 4 дэх хэсэг	“РМ” ХХК	Шүүхэд шилжсэн.
23	Нийслэлийн Прокурорын газар	2020	21.10-1 Битүүмжилсэн, хураан авсан эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх	“МӨ” ХХК	Ажиллагаанд байгаа.

Хүснэгт 2-ын үргэлжлэл


24	Нийслэлийн Прокурорын газар	2020	18.7-4 Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах	“ХН” ХХК	Шүүхээр эцэслэн шийдсэн.
25	Нийслэлийн Прокурорын газар	2020	22.5-3 Хахууль өгөх	“Б” ХХК	Ажилла- гаанд байгаа.
26	Баянзүрх дүүрэг	2020	24.3-3 Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах	“М” ХХК	Ажилла- гаанд байгаа.
27	Баянзүрх дүүрэг	2020	24.3-3 Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах	“СА” ХХК	Шүүхэд шилжсэн.

Прокурорын байгууллагын тоон мэдээг шинжилж үзэхэд нийт 27 хэргийн 15 нь нийслэл, дүүргийн прокурорын газарт, 12 нь хөдөө орон нутагт харьяалагдан хянагджээ. Хөдөө орон нутгийг ангилан авч үзвэл Баянхонгор аймагт нийт 12 гэмт хэргийн 7 үйлдэгдсэн нь 58.3 хувийг эзэлж байгаа бол Өмнөговьд хоёр, Орхонд нэг, Сэлэнгэд нэг, Өвөрхангайд нэг гэсэн тоон мэдээ байна.

УЕПГ-ын дүн мэдээнээс үзэхэд нийт 27 гэмт хэргийн хоёр нь буюу Эрүүгийн хуулийн 11.5 болон 21.10 дугаар зүйл нь хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх заалт биш тул үлдсэн 25 гэмт хэргийг ангилан авч үзлээ. Тус 25 гэмт хэргийн 27.9 дүгээр зүйл буюу Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих хоёр, 24.2 дугаар зүйл буюу Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг долоо, 24.3 дугаар зүйл буюу Химийн хорт, аюултай бодисыг хууль

бус эргэлтэд оруулах дөрөв, 22.5 дугаар зүйл буюу Хахууль өгөх тав, 24.6 дугаар зүйл буюу Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг гурав, бусад гэмт хэрэг дөрөв байна (График 2-ыг харна уу).

График 2. Хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг (2017-2021)



Шийдвэрлэсэн байдалд анализ хийж үзэхэд нийт 25 хэргийн найм нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн, зургаан хэргийг шүүхэд шилжүүлсэн, долоон хэрэг ажиллагаанд байгаа бол зургаан хэргийг хэрэгсэхгүй болгосон буюу түдгэлзүүлжээ. Дээрхээс үзэхэд хуулийн этгээдийн үйлдсэн 14 гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн болон шүүхэд шилжүүлсэн нь нийт хэргийн 56 хувь болж байгаа бол хэрэгсэхгүй болгосон, түдгэлзүүлсэн хэрэг нь нийт гэмт хэргийн 24 хувийг эзэлж байна. Эндээс хуулийн байгууллагад бүртгэгдэж, эрүүгийн хэрэг үүсгэсэн хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэж байгаа хувь харьцангуй өндөр байна гэж үзэж болохоор байна.

Шүүхээр шийдвэрлэсэн дээрх хэргийн заримын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж үзвэл:

1. Шүүхээр шийдвэрлэсэн хэргийн зүйл ангийг ангилан авч үзэхэд Хахууль өгөх хоёр, Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох нэг, Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах нэг, Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих нэг, Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах нэг, Хууль бусаар мод бэлтгэх нэг, бусад нэг гэсэн тоон мэдээлэл байна. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуульд заасан хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх 31 төрлийн гэмт хэргээс эдгээр найман төрлийн гэмт хэрэг гол төлөв үйлдэгдэж байгааг дээрх дүн мэдээ нотлон харуулж байна.
2. Шүүхээр шийдвэрлэсэн нийт гэмт хэргийн тавд тухайн гэмт хэргийг үйлдсэн хувь хүний үйлдлийг хамтад нь шийдвэрлэж, ял оногдуулсан бол гурван хэрэгт зөвхөн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан “Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан журмын дагуу хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгсөн эрх бүхий албан тушаалтныг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэснийг зөрчжээ.
3. Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн компаниудад эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх эрхийг нэг болон хоёр жилийн хугацаагаар хасаж, 20 сая төгрөгөөр торгох ял оногдуулан, торгох ялыг гурван жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэжээ. Эрүүгийн хуулийн 18.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг болон 22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн компаниудад 120 сая төгрөгийн торгох ял, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг нь хасах ял оногдуулжээ. Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн компанийн төмрийн хүдэр баяжуулах үйл ажиллагаа явуулах эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж, 50 сая төгрөгөөр торгох ял оногдуулжээ. Шүүхээс оногдуулсан торгох ялын хэмжээ болон торгох ялыг

хэсэгчлэн төлүүлэх хугацааг гурван жилээр тогтоож байгаагаас үзэхэд Эрүүгийн хуулийн цээрлүүлэх зорилгод нийцэж байгаа эсэхэд эргэлзээ төрүүлэхүйц байна гэж дүгнэж байна.

4. Гэмт хэрэг үйлдэж шүүхээр шийтгэгдсэн хуулийн этгээдүүдийн хувьд бүгд буюу 100 хувь хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) байгаа нь хувийн эрх зүйн хуулийн этгээдийг Эрүүгийн хуулийн үйлчлэлд хамруулжээ. Энэ нь Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээх хуулийн этгээдийг практикт Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт зааснаар ойлгон хэрэглэж байгааг нотолж байна.

3.2. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй өнөөгийн байдал, түүнд тулгамдаж байгаа зарим асуудлыг тодруулахаар цагдаагийн алба хаагч, прокурор, өмгөөлөгч, шүүгч зэрэг 103 хуульчаас санал асуулгаар судалгаа авлаа. Судалгаанд нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүрэг, хөдөө орон нутгаас Өвөрхангай, Баянхонгор, Хэнтий, Өмнөговь аймгийн шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгчдийн төлөөлөл оролцсон. Судалгаанд оролцогчдын албан тушаалыг тодруулбал шүүгч 32, өмгөөлөгч 27, прокурор, мөрдөгч 44 байгаа болно.⁷⁹

Хуульчдаас авсан санал асуулгын судалгааг дүгнэн үзэхэд судалгаанд оролцсон хуульчдын 90.2 хувь нь Монгол Улсад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгааг дэмжиж байна гэсэн төдийгүй энэхүү эрх зүйн зохицуулалттай болсон нь хуулийн этгээдийн зүгээс үйлдэгдэх гэмт хэргийг бууруулна гэж 57.3 хувь нь хүлээн зөвшөөрчээ.

Судалгаанд оролцсон хуульчдын 65 хувь нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаарх мэдлэгээ дунд гэж үнэлсэн хэдий ч 103 хуульчаас хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэж байсан туршлагыг нь авч үзвэл 26 хувь нь хуулийн этгээдэд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцож байжээ. Энэ нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлаар хуульчдын мэдлэг,

⁷⁹ Хавсралтаас дэлгэрэнгүйг үзнэ үү.

туршлага хангалтгүй байгааг нотолж байгаа бөгөөд хуульчдад энэ талаар сайтар мэдлэг, чадвар олгох хэрэгцээтэй байгааг харуулж байна.

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, тэрхүү асуудлыг шийдвэрлэх арга зам боловсруулах үүднээс эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн этгээдийн төрөл, хүлээлгэх шаардлагатай гэмт хэрэг, оногдуулах ялын төрөл, ялын үр нөлөө, хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудлыг тус санал асуулгаар тодруулахыг зорилоо.

Нэгдүгээрт, эрүүгийн хариуцлага хүлээх хуулийн этгээдийг тодорхойлохдоо судалгаанд оролцогчдын 59.2 хувь буюу дийлэнх нь хувийн эрх зүйн хуулийн этгээдээс гадна нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг хамруулах нь зүйтэй гэж үзсэн бол 33 хувь нь зөвхөн Иргэний хуулийн 25 дугаар зүйлд заасан хувийн эрх зүйн хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагын субъектээр тооцох саналтай байв. Энэ нь эрүүгийн хариуцлага хүлээх субъектийг хэрхэн ойлгох ойлголт судалгаанд оролцсон хуульчдын дунд харилцан адилгүй байгаа төдийгүй эрх зүйн зохицуулалт тодорхой бус байгааг харуулж байна.

Хоёрдугаарт, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа гэмт хэрэг, түүний төрлийг нэмэгдүүлэх шаардлагатай эсэх асуудлыг тодруулсан юм. Судалгаанд оролцогчдын хамгийн их хувь нь байгаль орчны болон татварын гэмт хэрэгт хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах нь зүйтэй гэж үзсэн бол эдгээрийн дараа авлигын гэмт хэрэг, үнэт цаас, хөрөнгийн зах зээлийн болон залилан мэхлэх гэмт хэрэг, цахим гэмт хэрэг өндөр хувьтай санал авчээ. Эрүүгийн хуулиар оногдуулж буй 31 төрлийн гэмт хэрэгт дээрх гэмт хэргүүд багтаж байгаа хэдий ч зарим төрлийн гэмт хэргийг хамруулах шаардлагатай нь судалгаагаар илэрсэн. Тухайлбал, залилан мэхлэх болон татварын гэмт хэрэг, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлагатай болохыг хуульч, хууль сахиулагчид илэрхийлжээ. Түүнчлэн хуульчид Зөрчлийн тухай хуулиар хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэвэл зохих зөрчлүүдэд байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчил, татварын хууль болон авто тээврийн тухай хууль зөрчих, аюулгүй ажиллагааны журам болон

барилгын тухай хууль зөрчих гэсэн зөрчлүүдийг нэрлэжээ. Дээрх судалгаа нь Монгол Улсад хуулийн этгээдийн зүгээс үйлдэж буй хамгийн түгээмэл гэмт хэрэг, зөрчил бөгөөд эдгээр нь байгаль орчин, татвар, эдийн засгийн салбарт үйлдэгдэж байгааг харуулж байна.

Гуравдугаарт, хуулийн этгээдэд Эрүүгийн хуулиар хүлээлгэж байгаа ялын төрөл, хэмжээ оновчтой эсэхийг санал асуулгаар тодруулахад Эрүүгийн хуулиар оногдуулж байгаа торгох ялын хэмжээг тохирч байна гэж 52 хувь, торгох ялын хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай гэж 30 хувь нь үзсэн бол зөрчилд оногдуулж буй торгуулийн шийтгэлийн хэмжээг бага буюу үр нөлөөгүй гэж 54 хувь нь үзжээ. Эндээс хуулийн этгээдэд оногдуулж байгаа торгуулийн шийтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай эсхүл тохирч байна гэж дийлэнх нь үзжээ. Мөн торгох ялаас гадна ялын бусад төрлийг нэмэгдүүлэх, ялангуяа татан буулгах, үйл ажиллагааг хориглох, эрх хасах гэсэн ялын төрлийг Эрүүгийн хуульд нэмж хуульчлах нь зүйтэй гэсэн саналыг тэд дэвшүүлжээ.

Дөрөвдүгээрт, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ гэмт хэрэг үйлдсэн хувь хүнд мөн давхар хариуцлага хүлээлгэх талаар хуульчид нэгдсэн ойлголт, мэдээлэлгүй байгаа нь судалгаагаар илэрсэн. Тухайлбал, судалгаанд оролцсон хуульчдын 26 хувь нь хуулийн этгээд, хувь хүнд давхар хариуцлага хүлээлгэнэ гэж үзсэн бол нэг мөр ойлголт байхгүй гэж 14 хувь, аль нэгийг нь сонгож хүлээлгэнэ гэж 12 хувь үзсэн нь онолын нэг мөр ойлголтгүй хуульч нэлээд байгааг харуулж байна.

Тавдугаарт, Эрүүгийн хууль 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн хэдий ч шүүхээр шийдвэрлэсэн хэрэг маргаан цөөн байгаа учир шалтгааныг тодруулахад хуульчдын туршлага дутмагтай холбоотой гэж 56 хүн, хэрэгжүүлэх хүсэл зориг муутай байна гэж 42 хүн үзсэн ба бусад саналыг дэлгэрүүлж үзэхэд авлига, нотлох баримт цуглуулах бэхжүүлэхэд хүндрэлтэй, эрх зүйн зохицуулалт боловсронгуй бус, гэмт хэргийн төрлийг нэмэгдүүлэхгүй бол ял завшиж байна зэрэг санал дэвшүүлжээ.

Дээрх асуудлыг нэмж тодруулах үүднээс хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах эрх зүйн зохицуулалтыг хэрхэн “амьдруулах” талаар асуухад хуульчдын 52 хувь нь Эрүүгийн хуульд байгаа

холбогдох зүйл заалтыг боловсронгуй болгох, ойлгомжгүй нэр томъёог тодорхойлох шаардлагатай гэж үзжээ. Цаашлаад Эрүүгийн хуулийг хэрхэн боловсронгуй болгох талаар асуухад хуульчдын зүгээс Эрүүгийн хуульд байгаа зарим нэр томъёог УДШ тайлбарлах, гадаад улсын туршлагаар тусгайлсан хууль батлах, эрүүгийн хариуцлага оногдуулах гэмт хэргийн төрлийг нэмэгдүүлэх, хуулийн этгээдийг хувийн эрх зүйн хуулийн этгээдээр хязгаарлахгүйгээр улс төрийн нам, шашны байгууллага зэрэг нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг хамруулах зэрэг санал гаргахын зэрэгцээ хуульчдыг сургах, тэдний мэдлэг чадварыг нэмэгдүүлэх нь тус заалтыг хэрэгжүүлэх хамгийн чухал хүчин зүйл гэж үзсэн байв.

ДҮГНЭЛТ

- Хуулийн этгээдийн гэмт хэрэг гэсэн ойлголт криминологийн шинжлэх ухаанд гарч ирсэнтэй давхцан хуулийн этгээд гэмт хэргийн субъект болохыг орчин үеийн эрүүгийн эрх зүйд хүлээн зөвшөөрөх боллоо. Хуулийн этгээдийг гэмт хэргийн субъект байх тухай Английн эрүүгийн эрх зүйг үндэслэгчдийн нэрт төлөөлөгчид болох Джеймс Ф.Стифен, Кортни С.Кенни болон Джером Холл нарын “Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хүсэл зоригоос үл хамааран учруулсан хор хохирол, үр дагаврыг бодитой үнэлэх замаар эрүүгийн хариуцлагын легаль зарчмыг хатуу нэхэн тооцно” гэсэн онол шийдвэрлэх нөлөө үзүүлсэн⁸⁰ бол одоогийн эрдэмтдийн төлөөлөл болох Японы эрдэмтэн Ито Кэсүкэ “Хуулийн этгээд нь ажилтны хүсэл зориг, үйл ажиллагааны үндсэн дээр нэгдсэн нэг хүсэл зоригийг илэрхийлж, үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тухайн байгууллагын нэрийн өмнөөс, байгууллагын хууль бус ажиллагаанаас үүдэлтэй гэмт хэрэг гарсан тохиолдолд ажилтан биш, харин хуулийн этгээд гэмт хэргийн субъект болно” гэж⁸¹, Английн эрүүгийн эрх зүйн нэрт эрдэмтэд болох Кард, Кросс болон Жонс нар “Компани, корпорац нь хуулийн этгээд болохын хувьд өөрийн үйл ажиллагааны төлөө хуульд заасан ямар ч хариуцлагыг хүлээх ёстой. Тэр тусмаа гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн ял шийтгэл хүлээх ёстой”⁸² гэжээ.
- Дэлхий нийтийн анхаарлыг татаж, орчин үеийн эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн

⁸⁰ Д.Баярсайхан, Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага, УБ., 2013, 32 дахь тал.

⁸¹ Ито Кэсүкэ, Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх онолын үндэслэгээ ба практик шаардлага, Эрүүгийн эрх зүйн шинэтгэл: Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал, ОУЭШХ-ын эмхэтгэл, 2017.

⁸² Д.Баярсайхан, Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага, УБ., 2013, 49 дэх тал.

этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт Монгол Улсын Эрүүгийн хуульд иж бүрэн тусгагдаж, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг эрүүгийн хариуцлагын зорилгыг биелүүлж байна. Эрүүгийн хуулийн есдүгээр бүлэгт заасан хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал нь онолын хувьд Английн загварыг баримталсан байх бөгөөд энэ нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл нь түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдийн дангаар болон хамтран шийдвэр гаргаж үйлдсэн үйлдлээр илэрнэ гэсэн нөхцөлөөс харагдаж байна. Гэвч цаашид Монгол Улс өөрийн эрх зүйн тогтолцоо, эрх зүйн соёлд суурилсан чиг хандлага, загварыг тодорхойлж, хэвшүүлэн хөгжүүлэх нь зүйтэй.

- Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ түүний үндэслэл, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах гэмт хэргийн төрөл, оногдуулах ял, албадлагын арга хэмжээний төрлийг тус тус Эрүүгийн хуулиар тодорхойлсон нь дэлхий нийтийн жишгээс хоцроогүй эрх зүйн зохицуулалт бий болгосон гэж үзэж байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд ял оногдуулахаар заасан гэмт хэргийн шинжийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа эсхүл хамтран шийдвэр гаргаж эсхүл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан нь хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэл болно” гэж тодорхойлсон нь (i) Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдсэн байх; (ii) хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд дангаар эсхүл хамтран шийдвэр гаргаж гэмт хэрэг үйлдсэн байх; (iii) хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө байх гэсэн гурван шинжийг агуулсан байх нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болохыг хуульчилжээ. Тус судалгаагаар сонгон авч судалсан Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Эрүүгийн хуульд хуулийн этгээдэд эрүүгийн

хариуцлага хүлээлгэх үндэслэлийг дээрхтэй адил гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрээр үйлдсэн, гэмт хэргийг хуулийн этгээдийн ашиг сонирхлын үүднээс үйлдсэн, гэмт хэргийг хуулийн этгээдийн зөвшөөрлөөр эсвэл зааварчилгааны дагуу үйлдсэн⁸³ гэсэн шинжүүдээр зүйлчилсэн бол Эстони Улсын Эрүүгийн хуулийн 14 дүгээр зүйлд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг “Хуульд заасан тохиолдолд хуулийн этгээд нь хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд эсвэл ахлах ажилтан хамтран, ганцаараа хийсэн үйлдлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээнэ” гэсэн нь мөн л манай улсад хуульчилсан гурван үндэслэлтэй давхцаж байна.

- Монгол Улсад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд тулгамдаж буй дараах асуудлууд байгаа нь судалгаагаар илэрлээ. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт хэрэгжээд багагүй хугацаа өнгөрсөн ч шүүхээр шийдвэрлэж буй гэмт хэргийн тоо бага байгаа нь гэмт хэргийг Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэж байгаатай холбоотой гэж судлаачид дүгнэж байна. Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд заасан гэмт үйлдлийн шинж давхацсан, хохирлын хэмжээ, хүний амь нас, эрүүл мэндэд учруулсан хор уршиг гэсэн цөөн шалгуураар “эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр бол” гэж гэмт хэрэг, зөрчлийг ялгах оролдлого хийсэн нь онолын хувьд ээдрээтэй, практикт хуульчид нэг мөр ойлголтод хүрээгүйгээс хуулийн давхардал, хийдэл бий болж байна.
- Эрүүгийн хуульд тодорхой бус зарим эрх зүйн зохицуулалтыг тодорхойлох, нэр томъёог тайлбарлах, онолын хувьд нэг мөр ойлголтод хүрэх, зарим төрлийн гэмт хэргийн төрлийг нэмэгдүүлэн хуульчлах, ялын бодлогыг өөрчлөн шинэчлэх зэргээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага хэдийнээ бий болжээ. Тухайлбал, санал асуулгын судалгаагаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн этгээдийг

⁸³ Вьетнам Улсын Эрүүгийн хуулийн 75 дугаар зүйл.

хэрхэн ойлгох талаар тодруулахад судалгаанд оролцогчдын 59.2 хувь буюу дийлэнх нь хувийн эрх зүйн хуулийн этгээдээс гадна нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг хамруулах нь зүйтэй гэж үзсэн бол 33 хувь нь зөвхөн Иргэний хуулийн 25 дугаар зүйлд заасан⁸⁴ хувийн эрх зүйн хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагын субъектээр тооцох саналтай гэсэн байна. Энэ нь эрүүгийн хариуцлага хүлээх субъектийг аль хүрээнд хамруулах талаарх ойлголт судалгаанд оролцсон хуульчдын дунд харилцан адилгүй байгаа төдийгүй эрх зүйн зохицуулалт нь тодорхой бус байгааг харуулж байна. Дэлхий нийтэд эрүүгийн хариуцлага хүлээх хуулийн этгээдийг нийтийн эрх зүйн болон хувийн эрх зүйн хуулийн этгээд гэж ангилах ба алинд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар дэлхийн улсууд өөр өөр байр суурьтай байдаг. Тухайлбал, Англи, АНУ, Франц, Дани зэрэг зарим улсад нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байхад БНХАУ, Литва, Молдова, Норвег, Эстони зэрэг зарим оронд зөвхөн хувийн эрх зүйн хуулийн этгээдийг гэмт хэргийн субъект гэж үзэх нь бий. Монгол Улсад Иргэний хуулийн 25 дугаар зүйл 1 дэх хэсэгт заасан хувийн эрх зүйн хуулийн этгээд 175,857 (нийт хуулийн этгээдийн 88.6 хувь нь энд хамаарна) байна. Эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн жишгийг үзэхэд гэмт хэрэг үйлдэж шийтгүүлсэн нийт хуулийн этгээд нь 100 хувь ХХК буюу хувийн эрх зүйн хуулийн этгээд байгаа юм. Иймд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн этгээдийг Иргэний хуулийн 25 дугаар зүйлд заасан хувийн эрх зүйн хуулийн этгээдийн хүрээнд тодорхойлон тайлбарлах нь зүйтэй. Харин цаашид энэхүү хүрээг өргөжүүлэн нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг хамруулах талаар анхаарах шаардлагатай. Учир нь сүүлийн жилүүдэд дэлхийн улсуудад шашны байгууллага гэмт хэрэг үйлдэх болсон төдийгүй Их сургуулийн гэмт хэрэг (*University crime*), Анагаахын гэмт хэрэг (*Medical crime*) зэрэг шинэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж эдгээрийн субъект нь нийтийн эрх зүйн хуулийн этгээд байх боллоо.

⁸⁴ Иргэний хуулийн 25 дугаар зүйл, 25.1 дэх хэсэг, “Төрийн мэдээлэл”, 2002 оны №7.

Иймд цаашдаа Монгол Улсад ч нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хэрэгцээ шаардлага бий болохыг үгүйсгэхгүй юм.

- Монгол Улсад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг шинжлэн үзэхэд тулгамдаж буй дараагийн асуудал бол “давхар хариуцлага хүлээлгэх” эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт байна. 2015 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн шударга ёсны зарчимд “Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн бол тухайн хүнийг ялаас чөлөөлж, хуулийн этгээдэд ял оногдуулна”⁸⁵ гэж хуулийн этгээдэд ял оногдуулахаар зохицуулснаар тухайн хувь хүнийг ялаас чөлөөлөхөөр тусгасан байжээ.⁸⁶ Харин 2017 оны тавдугаар сард УИХ-аар баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалд “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх талаар санхүүгийн хориг арга хэмжээ хэрэгжүүлэх олон улсын байгууллагын шинэчилсэн 40 зөвлөмж”-ийн гуравдугаарт “Хувь хүнд хариуцлага хүлээлгэсэн нь хуулийн этгээдийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй байх талаар хуульд тусгах шаардлагатай”⁸⁷ гэснийг дурдаж, Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан журмын дагуу хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгсөн эрх бүхий албан тушаалтныг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж хуульчилсан. Энэхүү заалт нь Монгол Улс нь Япон Улс, БНХАУ зэрэг Азийн зарим орны нэгэн адил давхар хариуцлагын тогтолцоог хуульчилсан орны нэг болсныг нотлон харуулж байна.⁸⁸ Гэвч энэхүү судалгаагаар дүн

⁸⁵ Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга), 1.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг.

⁸⁶ Эрүүгийн хууль, 2015.

⁸⁷ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, 2017. <http://mojha.gov.mn/uixd-huuli-tusul.html>

⁸⁸ Монгол Улсын нэгдэн орсон хэд хэдэн гэрээ конвенцод ийм заалт байгааг анхаарах нь зүйтэй.

шинжилгээ хийсэн шүүхийн 10 шийдвэрийн 50 хувь нь дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлж, тухайн гэмт хэргийг үйлдсэн хувь хүний үйлдлийг хамтад нь шийдвэрлэж ял оногдуулжээ. Иймд Эрүүгийн хуулийн “Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан журмын дагуу хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгсөн эрх бүхий албан тушаалтныг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй”⁸⁹ гэсэн заалтыг зөрчиж байгаа нь илэрч байгаа төдийгүй санал асуулгын судалгаагаар хуульчдын дөнгөж 34 хувь нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхийн зэрэгцээ эрх бүхий албан тушаалтанд давхар хариуцлага хүлээлгэнэ гэж хариулсан нь энэхүү давхар хариуцлагын зохицуулалтын талаар хуульчид нэлээд дутмаг ойлголттой байгааг мөн нотолж байна.

- Түүнчлэн Эрүүгийн хуульд тодорхойгүй байгаа “хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд” гэсэн нэр томъёог тодорхой болгох хэрэгцээ шаардлага байгаа нь эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх явцад илэрч байна. Монгол Улсын Компанийн тухай, Нөхөрлөлийн тухай, Хоршооны тухай зэрэг холбогдох хууль, тогтоомжуудыг харьцуулан судлаад “хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд” гэж хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохион байгуулах болон удирдах түвшний эрх бүхий албан тушаалтан болох ТУЗ, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэр гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдүүдээс гадна төлөөлөх эрх бүхий итгэмжлэлтэй этгээдийг хамруулан ойлгох нь зүйтэй гэж дүгнэлээ.
- Эрүүгийн хуульд хуулийн этгээдийн зүгээс үйлдсэн гэмт хэргийн хохирол, хор уршиг, нийгэмд аюултай байдал, гэмт хэргийн цар хүрээ зэрэг олон нөхцөл байдлыг харгалзан үзэж

⁸⁹ Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг.

хуулийн этгээдийг 10,000-80,000, 20,000-120,000, 40,000-200,000, 120,000-400,000, 200,000-400,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг буюу дээд хэмжээ нь 400 сая төгрөгөөр торгож байна. Монгол Улсын Эрүүгийн хуульд хуулийн этгээдийг торгох ялын хэмжээ 10-80 сая, 40-120 сая, 200-400 сая гэх мэтээр дээд болон доод интервалыг хол зөрүүтэй тогтоосон нь шүүгч торгох ялыг тухайн хуулийн этгээдийн нөхцөл байдлыг харгалзан ялгамжтай оногдуулах боломж олгосон хэдий ч торгох ялын дээд хэмжээг ихэсгэвэл гэмт хэргийн хэр хэмжээ, ялын үр нөлөө хоёрын уялдааг хангахад дөхөмтэй гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, шүүх торгох ял оногдуулахдаа ялын доод, дээд интервалын зөрүүг хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр буюу хуулийн этгээдийн хөрөнгийн хэмжээ, ял даах байдал, бизнесийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхэд үзүүлэх үр нөлөө зэргийг харгалзахын зэрэгцээ ялын үр нөлөөтэй байдал, тухайн гэмт хэргийн нийгмийн хор аюул, гэмт хэргийн хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэр, давтан үйлдэх эрсдэл зэргийг тооцон үзэх нь зүйтэй юм.

- Эрүүгийн хуулиар хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэж буй 31 гэмт хэргийг ял шийтгэлийн төрлөөр ангилан авч үзэхэд зөвхөн торгох ял оногдуулах есөн зүйл, торгох ял, эрх хасах арга хэмжээ оногдуулах 19 зүйл, татан буулгах албадлагын арга хэмжээ хэрэглэх хоёр зүйл байгаа нь хуулийн этгээдэд торгох ялыг эрх хасах албадлагын арга хэмжээтэй хамт хэрэглэх санц түгээмэл байгааг харуулж байна. Шүүхээр шийдвэрлэсэн хэргийг авч үзэхэд торгох ялыг эрх хасах ялтай хамт хэрэглэх нь түгээмэл байгаа бөгөөд торгох ялыг нэгээс гурван жилд хэсэгчлэн төлүүлэхээр шийдсэн байна. Иймд хуулийн этгээдэд оногдуулж буй ялын төрлийг алтернатив байдлаар олшруулах, эрх хасах албадлагын арга хэмжээг ял болгон өөрчлөх зэргийг анхааран үзэх нь зүйтэй.

ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийг онол, практикийн түвшинд боловсронгуй болгох, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд дараах зөвлөмжийг дэвшүүлж байна.

1. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн этгээд, түүний төрлийг тодорхойлох. Ингэхдээ Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт зааснаар эрүүгийн хариуцлага хүлээх хуулийн этгээдийг тодорхойлон тайлбарлах нь зүйтэй.
2. Давхар хариуцлагын тогтолцоо буюу “Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан журмын дагуу хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгсөн эрх бүхий албан тушаалтныг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлж хэвших, хуульчдад энэ талаар нэгдсэн ойлголт бий болгох нь зүйтэй.
3. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан байгаль орчны, татвар, эдийн засгийн, залилан, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг зэрэг хуулийн этгээд түгээмэл үйлддэг зарим төрлийн гэмт хэрэгт хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулахаар эрх зүйн зохицуулалт бий болгох. Энэ нь Эрүүгийн хуулийн урьдчилан сэргийлэх зорилгыг хангахад дөхөм болох учиртай.
4. Хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах ялын төрлийг нэмэгдүүлэх буюу албадлагын арга хэмжээг ял болгон

өөрчлөх шаардлагатай. Түүнчлэн торгох ялын дээд хэмжээ, торгох ялыг биелүүлэх хугацааг оновчтой тогтоож, ялын цээрлүүлэх зорилгод нийцүүлэн, нийгэмд үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлэх нь зүйтэй.

5. Практик хэрэгжилтийг сайжруулах, хуульд тодорхойгүй, нэг мөр ойлголтод хүрээгүй асуудлыг илрүүлэн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг бүрд ял шийтгэл оногдуулах байдлаар эрүүгийн хариуцлагын зорилгыг хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Үүний тулд Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд заасан гэмт хэрэг, зөрчлийг ялган зүйлчлэх, давхардал хийдлийг арилгах шаардлагатай.
6. Хуульчид, хууль сахиулагч зэрэг Эрүүгийн хуулийг практикт хэрэгжүүлж буй ажилтнуудыг хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх ерөнхий онол, эрүүгийн эрх зүйн зохицуулалт болон процессын зүйл, заалтын талаар нэгдсэн сургалтад хамруулах, дагнан мэргэшүүлэх нь зүйтэй.
7. Хуулийн байгууллагуудын зүгээс гаргаж буй хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн дүн мэдээний чанарыг сайжруулах, хоорондын зөрүүтэй байдлыг арилгах, цар хүрээг өргөжүүлэх, уялдаа холбоотой нэгдсэн сантай болгох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын статистик мэдээг хуулийн этгээд гэсэн тусгай субьектээр ангилан гаргах. Ингэхдээ аль болох өргөн цар хүрээнд буюу хуулийн этгээдийн төрөл, учруулсан хохирол, хор уршиг, хүний амь нас эрсэдсэн эсэх зэргээр баганын тоог нэмэгдүүлэх нь цаашид энэ чиглэлээр судалгаа хийхэд дөхөмтэй болохоор байна.
8. Эрүүгийн хуулийн есдүгээр бүлэгт заасан зарим заалтыг хууль зүйн техник, утга агуулгын алдаа, давхардал, хийдэлгүйгээр тодорхойлж, боловсронгуй болгох нь зүйтэй.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

А. Монгол хэлээр

Нэг. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль

1. Эрүүгийн хууль, 2015.
2. Эрүүгийн хууль, 2002.
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2015.
4. Зөрчлийн тухай хууль, 2015.
5. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017.
6. Компанийн тухай хууль, 2011.
7. Иргэний хууль, 2002.
8. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, 2018.

Хоёр. Олон улсын гэрээ

1. Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, 2003.
2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц, 1988.
3. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, 2004.
4. Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенц, 1999.
5. Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагын дөчин зөвлөмж, 1990.
6. Дэлхийн Эрүүгийн загвар хууль, 2007.

Гурав. Эрдэм шинжилгээний бүтээл, ном

1. Д. Баярсайхан, Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага, УБ., 2013.
2. С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж, УБ., 2017.

3. Хуулийн этгээдийн эрх зүйн байдал, хариуцлага: Харьцуулсан эрх зүйн асуудал, УБ., 2010.
4. “Эрүүгийн эрх зүйн шинэтгэл: Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал”, олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ., 2017.
5. “Эдийн засгийн гэмт хэрэг” гарын авлага, “Шүүхийн сургалтын чадавхыг бэхжүүлэх нь” төсөл, УБ., 2017.

Дөрөв. Эрдэм шинжилгээ, судалгааны ажил

1. Б.Одонгэрэл, “Монгол Улсад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь” магистрын ажил, Кюүшүгийн их сургуулийн Хуулийн сургууль, 2011.
2. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэмт хэргийн зүйлчлэл, 2012.

Тав. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл

1. Д.Баярсайхан, Хуулийн этгээд эрүүгийн гэмт хэргийн субъект болох нь: Харьцуулсан эрх зүйн зарим асуудал, Хуулийн этгээдийн эрх зүйн байдал, хариуцлага: Харьцуулсан эрх зүйн асуудал, ОУЭШХ-ын эмхэтгэл, УБ., 2010.
2. Д.Баярсайхан, Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлага: Онолын үндэслэл, чиг хандлага, Эрүүгийн эрх зүйн шинэтгэл: Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал, ОУЭШХ-ын эмхэтгэл, УБ., 2017.
3. Г.Гантөмөр, Монгол Улсын эрүүгийн эрх зүйгээр хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлага, хэрэгжүүлэх арга зам, Хуулийн этгээдийн эрх зүйн байдал, хариуцлага: Харьцуулсан эрх зүйн асуудал. ОУЭШХ-ын эмхэтгэл, 2010.
4. Ито Кэсүкэ, Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх онолын үндэслэгээ ба практик шаардлага, Эрүүгийн эрх зүйн шинэтгэл: Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал, ОУЭШХ-ын эмхэтгэл, 2017.
5. Б.Одонгэрэл, Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал: ОХУ-ын эрдэмтдийн санал, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2008 оны №2.

6. Б.Одонгэрэл, Эрүүгийн хариуцлага оногдуулах хуулийн этгээд, түүний төлөөллийн асуудал, “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл, 2018 оны №4.

Долоо. Гадаадын улсуудын хууль

1. Вьетнам Улсын Эрүүгийн хууль, 2011.
2. Эстони Улсын Эрүүгийн хууль, 2001.
3. БНХАУ-ын Эрүүгийн хууль, 1997.
4. Япон Улсын Эрүүгийн хууль, 1907.
5. Япон Улсын Компанийн тухай хууль, 2005.

Найм. Цахим эх сурвалж

1. www.legalinfo.mn
2. <http://mojha.gov.mn/images/files/huuliintusul/taniltsuulga-eruu-20161111.pdf>
3. www.mongolbank.mn
4. Sadhana Singh, Компанийн гэмт хэрэг ба хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага, https://www.unafei.or.jp/publications/pdf/RS_No76/No76_10PA_Singh.pdf
5. Cameron Dunstan-Smith, Jonathan Ripley-Evans, Өмнөд Африк дахь цагаан захтны гэмт хэрэг: Хууль ба хэрэглээ, 2019 оны 11 сар.
6. Jonathan Clough. Improving the Effectiveness of Corporate Criminal Liability: Old Challenges in a Transnational World, www.jstor.org
7. <https://hsfnotes.com/africa/2019/11/21/south-africa-white-collar-crime-law-and-practice/>
8. Zoltan Hegymegi-Brakonyi, Corporate Liability in Hungary <https://globalcompliancenews.com/white-collar-crime/corporate-liability-in-hungary/>
9. Arne Gutermann and Koen De Winter (Baker McKenzie Belgium), Бельги улсын хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага, <https://globalcompliancenews.com/white-collar-crime/corporate-liability-in-belgium/>
10. Кенго Нишигаки болон Ёошиаки Муто. Эрүүгийн хэрэгт компанид хариуцлага хүлээлгэх нь, <https://globalcompliancenews.com/white-collar-crime/corporate-liability-japan/>

11. Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага: Дэлхийн улсуудын эрх зүйн зохицуулалт ба практик https://data.allens.com.au/pubs/pdf/ibo/CorporateCriminalLiabilityPublication_2016.pdf
12. Allens Arthur Robinson. Corporate Culture' as a Basis for the Criminal Liability of Corporations, <https://www.business-humanrights.org/sites/default/files/reports-and-materials/Allens-Arthur-Robinson-Corporate-Culture-paper-for-Ruggie-Feb-2008.pdf>
13. https://www.researchgate.net/publication/309041784_THE_CASE_FOR_CORPORATE_CRIMINAL_LIAB

Б. Гадаад хэлээр


1. Mark Pieth and Radha Ivory, Corporate criminal liability, Springer printing, 2011.
2. Jaan Ginter, Criminal Liability of Legal Persons in Estonia, JURIDICA INTERNATIONAL XVI, 2009.
3. Henry N. Pontell and Gilbert Geis (2007), International Handbook of White-Collar and Corporate crime, Springer Science+ Business Media LLC.
4. Лев Иванов (2008), Немецкие правоведы исследуют вопросы публичной ответственности юридических лиц, журнал “Право и экономика”, №12.
5. Markus Wagner (1999), Corporate Criminal Liability, paper for the International Society for the Reform of Criminal Law 13th International Conference.

ХАВСРАЛТ

СУДАЛГААНЫ ҮР ДҮН


АСУУЛТ 1. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар өөрийн мэдлэгийг үнэлж буй байдал

График 1. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаарх хуульчдын мэдлэгийн үнэлгээ



Судалгаанд оролцсон нийт 103 оролцогчийн 29 нь буюу 28.2 хувь нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар өөрийн мэдлэгийг “сайн” гэж үнэлсэн бол 67 оролцогч буюу 65 хувь нь “дунд”, долоон оролцогч буюу 6.8 хувь нь энэ талын мэдлэгээ “муу” гэж үнэлжээ. Өөрөөр хэлбэл, ойролцоогоор арван хүн тутмын долоо нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар мэдлэг дутмаг байна.


График 2. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаарх албан тушаалтнуудын мэдлэгийн үнэлгээ



Судалгаанд оролцогчдын хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаарх мэдлэгийг албан тушаалаар нь авч үзвэл дөрвөн шүүгч тутмын нэг, гурван өмгөөлөгч тутмын нэг, мөн прокурор, мөрдөгчдийн гурван хүн тутмын нэг нь мэдлэгээ сайн хэмээн үнэлжээ.


АСУУЛТ 2. Монгол Улсад Эрүүгийн хуулиар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хуульчилсныг дэмжиж буй байдал

График 3. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсныг дэмжиж буй байдал



Судалгаанд оролцогчдын дийлэнх буюу арван хүн тутмын ес нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хуульчилсныг дэмжжээ.


График 4. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсныг дэмжиж буй байдал (албан тушаалаар)



Эрүүгийн хуулиар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хуульчилсныг судалгаанд оролцогчид дэмжиж буй эсэхийг албан тушаалаар нь авч үзэхэд гурван өөр төрлийн албан тушаалтнууд бүгд 80 болон түүнээс дээш хувьтай дэмжсэн байна.


АСУУЛТ 3. Эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээх “хуулийн этгээд”-ийг тодорхойлж буй байдал

График 5. Эрүүгийн хуульд заасан “хуулийн этгээд” гэдгийг тодорхойлж буй байдал



Судалгаанд оролцогчдын 61 нь буюу 59.2 хувь нь эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээх хуулийн этгээдэд “Иргэний хуулийн 25 дугаар зүйлд заасан дээр нэмээд төрийн, шашны, хэвлэл мэдээллийн байгууллага, их, дээд сургууль, эмнэлэг гэх мэт нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг хамруулж ойлгоно” гэсэн бол 34 оролцогч буюу 33 хувь нь “Иргэний хуулийн 25 дугаар зүйлд заасан ашгийн (компани, нөхөрлөл), ашгийн бус (холбоо, сан, хоршоо) гэсэн хүрээнд ойлгоно” гэж үзсэн ба харин найман оролцогч буюу 7.8 хувь нь зөвхөн компанийг ойлгоно гэжээ. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх хуулийн этгээдийн тухай ойлголт нийт оролцогчдод харилцан адилгүй байна.

График 6. Эрүүгийн хуульд заасан “хуулийн этгээд” гэдгийг тодорхойлж буй байдал (албан тушаалаар)




Судалгаанд оролцсон шүүгчдийн 53.1 хувь, өмгөөлөгчдийн 66.7 хувь, прокурор, мөрдөгчдийн 59.1 хувь нь эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх хуулийн этгээд бол Иргэний хуулийн 25 дугаар зүйл болон түүн дээр нэмэлтээр төрийн, шашны, хэвлэл мэдээллийн байгууллага, их, дээд сургууль, эмнэлэг гэх мэт нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг хамруулж ойлгоно гэж үзжээ.

Мөн Эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх хуулийн этгээд нь зөвхөн компани гэж үзэж буй оролцогчдын дөрөв нь өмгөөлөгч байгаа бол Иргэний хуулийн 25 дугаар зүйлд заасан этгээдүүдийг ойлгоно гэж үзэж буй оролцогчдын дийлэнхийг прокурор, мөрдөгч буюу 16 оролцогч, харин Иргэний хуулийн 25 дугаар зүйл болон түүн дээр нэмэлтээр төрийн, шашны, хэвлэл мэдээллийн байгууллага, их, дээд сургууль, эмнэлэг гэх мэт нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг хамруулж ойлгоно гэж хариулсан оролцогчдын дийлэнх буюу 26 нь прокурор, мөрдөгч байна.


АСУУЛТ 4. Эрүүгийн хуульд зааснаар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх онц шаардлагатай гэмт хэргийн төрөл

График 7. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх онц шаардлагатай гэмт хэргийн төрөл



Судалгаанд оролцсон нийт 103 оролцогч тус асуултад найман төрлийн хариултын хувилбараас давхардсан байдлаар сонголт хийсэн бөгөөд нийт 278 санал цугласныг тоогоор болон хувиар илэрхийлэхэд хамгийн их буюу 71 болон 61 санал нь байгаль орчны болон татварын гэмт хэргийг нэрлэсэн байна. Харин хамгийн бага буюу 11 санал хүн худалдаалах гэмт хэрэгт цуглажээ.

График 8. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх онц шаардлагатай гэмт хэргийн төрөл (албан тушаалаар)



Бусад* саналд хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, бүх гэмт хэрэгт хуулийн этгээдийг субъектээр тооцох гэсэн хоёр санал бичигдсэн болно.

АСУУЛТ 5. Зөрчлийн тухай хуулиар хуулийн этгээдэд шийтгэл хүлээлгэж байгаа хамгийн түгээмэл зөрчил

График 9. Зөрчлийн тухай хуулиар хуулийн этгээдэд шийтгэл хүлээлгэж байгаа хамгийн түгээмэл зөрчил




Судалгаанд оролцсон нийт 103 оролцогч тус асуултад 11 төрлийн хариултын хувилбараас давхардсан байдлаар сонголт хийсэн бөгөөд нийт 205 санал цугласныг тоогоор болон хувиар илэрхийлэхэд хамгийн их буюу 55 санал нь байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчлийг нэрлэсэн байна. Харин хамгийн бага санал болох 33 санал нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль зөрчихтэй холбоотой асуудал байлаа.

Бусад* гэх хариулт өгсөн дөрвөн саналыг График 10-т харуулав.

График 10. Зөрчлийн тухай хуулиар хуулийн этгээдэд шийтгэл хүлээлгэж байгаа хамгийн түгээмэл зөрчил (нэмэлт санал)




График 11. Зөрчлийн тухай хуулиар хуулийн этгээдэд шийтгэл хүлээлгэж байгаа хамгийн түгээмэл зөрчил (албан тушаалаар)



Албан тушаалаар ангилсан байдлаас харахад санал асуулгад оролцсон гурван өөр албан тушаалтан адилхан санал буюу байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журам, татварын хуулийг түлхүү үндэслэн хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэдэг гэжээ.

АСУУЛТ 6. Хуулийн этгээдэд хууль зүйн хариуцлага оногдуулсан туршлагын төрөл

График 12. Хуулийн этгээдэд хууль зүйн хариуцлага оногдуулсан туршилага



Хуулийн этгээдэд хууль зүйн хариуцлага оногдуулсан төрлийг оролцогчид өөрсдийн туршлагад үндэслэн 5 хариултаас давхардуулан сонгосон бөгөөд нийт 115 хариулт цугласан. Судалгаанд оролцогчдын хариултаас харахад 37 хувь буюу хамгийн их хувь нь хуулийн этгээдэд ямар нэгэн хариуцлага оногдуулж байгаагүй гэсэн бол 26 хувь нь эрүүгийн хариуцлага, 25 хувь нь зөрчлийн хариуцлага, есөн хувь нь захиргааны хариуцлага, 3 хувь нь иргэний хариуцлагын төрөл байна.

Харин хуулийн этгээдэд хууль зүйн хариуцлага оногдуулж байсан эсэхийг албан тушаалын ангиллаар График 13-т харуулав.


График 13. Хуулийн этгээдэд хууль зүйн хариуцлага оногдуулсан төрөл (албан тушаалаар)



Албан тушаалаар ангилсан байдлаас харахад аль аль төрлийн албан тушаалд хуулийн этгээдэд хууль зүйн хариуцлага оногдуулж байсан туршлага бага байна (33-44 хувь).


АСУУЛТ 7. Зөрчлийн тухай хуулиар хуулийн этгээдэд оногдуулж байгаа торгуулийн хэмжээ үр нөлөөтэй байгаа эсэх

График 14. Зөрчлийн тухай хуулиар оногдуулж байгаа торгуулийн хэмжээний үр нөлөө



Судалгаанд оролцсон нийт оролцогчдын хоёр хүн тутмын нэг нь Зөрчлийн тухай хуулиар оногдуулж байгаа торгуулийн хэмжээ бага, үр нөлөөгүй байна гэж үзэж байгаа бол бусад оролцогчид торгуулийн хэмжээг тохирч байна (38.8 хувь), харин 8.8 хувь нь хэт өндөр байна гэж үзжээ.

График 15. Зөрчлийн тухай хуулиар оногдуулж байгаа торгуулийн хэмжээ үр нөлөөтэй байгаа эсэх (албан тушаалаар)




Албан тушаалын ангиллаар авч үзэхэд шүүгчдийн 59.4 хувь, өмгөөлөгчдийн 55.6 хувь, прокурор, мөрдөгчдийн 45.5 хувь нь Зөрчлийн тухай хуулиар оногдуулж байгаа торгуулийн хэмжээ бага,

үр нөлөөгүй байна гэж үзжээ. Харин торгуулийн хэмжээ их байна гэх саналыг прокурор, мөрдөгчид илүүтэй өгч байгаа (15.9 хувь) бол шүүгч, өмгөөлөгчдөөс тус бүр нэг хүн л торгуулийн хэмжээг их гэж үздэг байна.

АСУУЛТ 8. Эрүүгийн хуулиар хуулийн этгээдийг торгох ялын дээд хэмжээ 400 сая төгрөг байгаа нь үр нөлөөтэй эсэх

График 16. Ялын дээд хэмжээ 400 сая төгрөг байгаа нь үр нөлөөтэй эсэх




Бусад* саналд дараах дөрвөн санал нэмэлтээр бичигдсэн:

- Бусад төрлийн ялыг нэмэгдүүлэх;
- Татан буулгах ял шаардлагатай;
- Торгохоос гадна үйл ажиллагааг зогсоох;
- Учруулсан хохиролтой уялдуулан хэмжээг тогтоох.

Нийт судалгаанд оролцогчдын 10 хүн тутмын тав нь ялын хэмжээг тохирч байна, гурав нь ялын дээд хэмжээг хоёр дахин нэмэгдүүлэх хэрэгтэй, хоёр нь эсрэгээрээ ялын хэмжээг бууруулах хэрэгтэй гэсэн бол үлдсэн нэг нь бусад саналыг дэвшүүлжээ.

График 17. Ялын дээд хэмжээ 400 сая төгрөг байгаа нь үр нөлөөтэй эсэх (албан тушаалаар)



Хуулийн этгээдийн торгох ялын дээд хэмжээ 400 сая төгрөг байгаа нь үр нөлөөтэй эсэхийг албан тушаалаар нь шинжлэхэд “энэ хэмжээ тохирч байна” гэх хариултыг судалгаанд оролцогчдын дийлэнх нь сонгожээ.

АСУУЛТ 9. Эрүүгийн хуулиар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нэн шаардлагатай гэмт хэргүүд

Тус асуулт нь задгай хариулттай байсан бөгөөд үр дүнг нийт судалгаанд оролцогчдын санал болон албан тушаал бүрээр жагсааж гаргав.

Хүснэгт 1. Эрүүгийн хуулиар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нэн шаардлагатай гэмт хэргүүд (нийт)

Нийт өгсөн санал	Тоо	Эзлэх хувь
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	25	23 хувь
Татварын гэмт хэрэг	13	12 хувь
Авлигын гэмт хэрэг	10	9 хувь
Албан тушаалын гэмт хэрэг	6	5 хувь
Залилах гэмт хэрэг	5	5 хувь
Эдийн засгийн гэмт хэрэг	5	5 хувь
Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох	4	4 хувь
Даатгалын гэмт хэрэг	3	3 хувь
Авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах	2	2 хувь
Банк хууль бусаар байгуулах, банкны төлбөрийн чадвар алдагдуулах	2	2 хувь
Мөнгө угаах	2	2 хувь
Олон нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2	2 хувь
Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	2	2 хувь
Худал мэдээлэл тараах	2	2 хувь
Цахим гэмт хэрэг	2	2 хувь
Аюулгүй ажиллагааны гэмт хэрэг	1	1 хувь
Банкны гэмт хэрэг	1	1 хувь
Барилгын гэмт хэрэг	1	1 хувь
Барилгын журам зөрчсөн	1	1 хувь

Хүснэгт 1-ийн үргэлжлэл

Барилгын хууль зөрчих	1	1 хувь
Газрын харилцааны журам зөрчсөн	1	1 хувь
Гүтгэх	1	1 хувь
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг	1	1 хувь
Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих	1	1 хувь
Зориуд, зохиомлоор дампуурах	1	1 хувь
Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх зөрчих	1	1 хувь
Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах	1	1 хувь
Нотариатын үйл ажиллагаатай холбоотой гэмт хэрэг	1	1 хувь
Тусгай зөвшөөрөл	1	1 хувь
Үндэслэлгүйгээр хөрөнгөжих	1	1 хувь
Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах	1	1 хувь
Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1	1 хувь
Хууль бусаар даатгалын нөхөн төлбөр авах	1	1 хувь
Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1	1 хувь
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргүүд	1	1 хувь
Хүний хувийн болон улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	1	1 хувь
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах	1	1 хувь
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах	1	1 хувь

Хүснэгт 1-ийн үргэлжлэл

Хээл хахууль өгөх, авах	1	1 хувь
Цахим мэдээллийн аюулгүй байдал	1	1 хувь
Чанар муутай барилга бариулах	1	1 хувь
Нийт саналын тоо	111	100 хувь

Нийт саналаас харахад судалгаанд оролцогчид хамгийн их санал өгч, хариуцлага хүлээлгэх шаардлагатай гэж үзсэн гэмт хэргүүдээр хүрээлэн байгаа орчны (23 хувь), татварын (12 хувь), авлигын гэмт хэрэг (9 хувь)-үүдийг нэрлэжээ. Албан тушаал бүрийн саналыг Хүснэгт 2-т тусгав.

Хүснэгт 2. Эрүүгийн хуулиар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нэн шаардлагатай гэмт хэргүүд (албан тушаалаар)

Прокурор, мөрдөгчдийн санал	Тоо	Эзлэх хувь
Татварын гэмт хэрэг	8	19 хувь
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	8	19 хувь
Даатгалын гэмт хэрэг	3	7 хувь
Авлигын гэмт хэрэг	2	5 хувь
Банк хууль бусаар байгуулах, банкны төлбөрийн чадвар алдагдуулах	2	5 хувь
Авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах	1	2 хувь
Албан тушаалын гэмт хэрэг	1	2 хувь
Банкны гэмт хэрэг	1	2 хувь
Барилгын хууль зөрчих	1	2 хувь
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг	1	2 хувь

Хүснэгт 2-ын үргэлжлэл

Залилах гэмт хэрэг	1	2 хувь
Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих	1	2 хувь
Зориуд, зохиомлоор дампуурах	1	2 хувь
Мөнгө угаах	1	2 хувь
Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах	1	2 хувь
Нотариатын үйл ажиллагаатай холбоотой гэмт хэрэг	1	2 хувь
Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	1	2 хувь
Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1	2 хувь
Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох	1	2 хувь
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах	1	2 хувь
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах	1	2 хувь
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	1	2 хувь
Цахим мэдээллийн аюулгүй байдал	1	2 хувь
Эдийн засгийн гэмт хэрэг	1	2 хувь
Нийт	42	100 хувь
Өмгөөлөгчдийн санал	Тоо	Эзлэх хувь
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	3	18 хувь
Залилах гэмт хэрэг	2	12 хувь

Хүснэгт 2-ын үргэлжлэл


Татварын гэмт хэрэг	2	12 хувь
Цахим гэмт хэрэг	2	12 хувь
Авлигын гэмт хэрэг	1	6 хувь
Аюулгүй ажиллагааны гэмт хэрэг	1	6 хувь
Барилгын гэмт хэрэг	1	6 хувь
Мөнгө угаах	1	6 хувь
Тусгай зөвшөөрөл	1	6 хувь
Үндэслэлгүйгээр хөрөнгөжих	1	6 хувь
Худал мэдээлэл тараах	1	6 хувь
Эдийн засгийн гэмт хэрэг	1	6 хувь
Нийт	17	100 хувь
Шүүгчдийн санал	Тоо	Эзлэх хувь
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	13	25 хувь
Авлигын гэмт хэрэг	7	13 хувь
Албан тушаалын гэмт хэрэг	5	10 хувь
Татварын гэмт хэрэг	3	6 хувь
Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох	3	6 хувь
Эдийн засгийн гэмт хэрэг	3	6 хувь
Залилах гэмт хэрэг	2	4 хувь
Олон нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2	4 хувь

Хүснэгт 2-ын үргэлжлэл

Авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах	1	2 хувь
Барилгын журам зөрчсөн	1	2 хувь
Газрын харилцааны журам зөрчсөн	1	2 хувь
Гүтгэх	1	2 хувь
Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх зөрчих	1	2 хувь
Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	1	2 хувь
Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах	1	2 хувь
Худал мэдээлэл тараах	1	2 хувь
Хууль бусаар даатгалын нөхөн төлбөр авах	1	2 хувь
Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1	2 хувь
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргүүд	1	2 хувь
Хүний хувийн болон улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	1	2 хувь
Хээл хахууль өгөх, авах	1	2 хувь
Чанар муутай барилга бариулах	1	2 хувь
Нийт	52	100 хувь

АСУУЛТ 10. Монгол Улсад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалттай болсон нь хуулийн этгээдийн зүгээс үйлдэгдэх гэмт хэргийг бууруулах эсэх

График 18. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалттай болсон нь гэмт хэргийг бууруулах эсэх



Судалгаанд оролцогчдын 57.3 хувь нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалттай болсон нь хуулийн этгээдийн зүгээс үйлдэгдэх гэмт хэргийг бууруулна гэдэгт итгэлтэй байгаа бол 15.5 хувь нь итгэлгүй, харин 27.2 хувь нь одоогоор эргэлзэж байна гэж хариулжээ.

График 19. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалттай болсон нь гэмт хэргийг бууруулах эсэх (албан тушаалаар)





График 19-д харагдаж байгаачлан хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалттай болсон нь хуулийн этгээдийн зүгээс үйлдэгдэх гэмт хэргийг бууруулна гэдэгт судалгаанд оролцсон гурван төрлийн албан тушаалтнуудын 55 болон түүнээс дээш хувь нь итгэлтэй байна гэж хариулжээ.

АСУУЛТ 11. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх заалт хэрэгжиж эхэлснээс хойш дөрвөн жил гаруйн хугацаанд шүүхээр хянан шийдвэрлэсэн хэрэг маш бага байгаагийн учир шалтгаан

График 20. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх заалт хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд шүүхээр хянан шийдвэрлэсэн хэрэг маш бага байгаагийн учир шалтгаан



Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх заалт хэрэгжиж эхэлснээс хойших дөрвөн жил гаруйн хугацаанд шүүхээр хянан шийдвэрлэсэн хэрэг маш бага байгаагийн учир шалтгааныг тодруулахад судалгаанд оролцогчдын 44 хувь нь хуульчдын туршлага бага гэж үзэж байгаа бөгөөд энэ нь хамгийн өндөр хувь байна. Үүний араас заалтыг хэрэгжүүлэх хүсэл зориг муу байна гэж 33 хувь, бусад санал дэвшүүлсэн 13 хувь байгаа бол 10 хувь нь хуулийн этгээд гэмт хэрэг үйлдэхгүй байна гэж үзжээ.


Бусад гэх сонголтыг сонгож саналаа илэрхийлсэн нь 17 байгаа бөгөөд хариултыг доор хүснэгтээр үзүүлээ.

Хүснэгт 3. Албан тушаал тус бүрээр нэмэлтээр нэрлэсэн шалтгаанууд

Шүүгч
Авлига
Илрүүлдэггүй, чадвар, нөөц муу (2 санал)
Мэдлэг, хууль хэрэглээний чадвар муу
Прокуроруудын мэдлэг, хүсэл зоригтой холбоотой
Туршлага байхгүй
Хуулийн байгууллагын мэргэшил, мэдлэг дутмаг
Хуулийн заалтыг нэг бүрчлэн задалж тодорхой болгох
Хуулийн зохицуулалт муу, гэмт хэргийн илрүүлэлт муу
Хууль хэрэглэх чадвар муугаас ял завшиж байна
Өмгөөлөгч
Шүүх, прокурор, мөрдөгч хуулийг хэрэглэхийг хүсэхгүй байна
Гэмт хэргийг илрүүлэх мэдлэг, туршлага дутмаг
Бусад гэмт хэрэгтэй харьцуулахад цөөн гардаг
Прокурор, мөрдөгч
Авлига
Илрүүлэлт муу
Нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх чадвар муу
Эрх зүйн орчин боловсронгуй биш

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх заалт хэрэгжиж эхэлснээс хойш дөрвөн жил гаруйн хугацаанд шүүхээр хянан шийдвэрлэсэн хэрэг маш бага байгаагийн учир шалтгааныг албан тушаалаар График 21-д үзүүлэв.


График 21. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх заалт хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд шүүхээр хянан шийдвэрлэсэн хэрэг маш бага байгаагийн учир шалтгаан (албан тушаалаар)



Албан тушаалын ангиллаар авч үзэхэд шүүгч, өмгөөлөгч, прокурор, мөрдөгчдийн аль алины дийлэнх нь буюу албан тушаал тус бүрийн 40 гаруй хувь нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх заалт хэрэгжиж эхэлснээс хойших дөрвөн жил гаруйн хугацаанд шүүхээр хянан шийдвэрлэсэн хэрэг маш бага байгаагийн учир шалтгаан нь хуульчдын туршлага дутмаг байгаатай холбоотой гэж үзжээ.

АСУУЛТ 12. Хуулийн этгээдэд хууль зүйн хариуцлага оногдуулсан заалтыг “амьдруулах”-ын тулд хийх ажлын талаарх санал


График 22. Эрүүгийн хуулийн заалтыг хэрэгждэг болгохын тулд авах арга хэмжээ



Бусад* хэсэгт дараах гурван санал нэмэлтээр бичигдсэн:

- Мөрдөн шалгах, түүнд хяналт тавих ажиллагаа муу;
- Хуулийн этгээдийг шалгах, яллах процессын заалтыг УДШ тайлбарлах;
- Хуульчдыг мэргэшүүлэх, сургалтад хамруулах.


График 23. Эрүүгийн хуулийн заалтыг хэрэгждэг болгохын тулд авах арга хэмжээ (албан тушаалаар)



Эрүүгийн хуулийн заалтыг амьдруулахын тулд шүүгчид эрүүгийн хуулийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох (35 хувь), гаднын туршлагыг нэвтрүүлэх (19 хувь) арга хэмжээ авах саналтай байгаа бол өмгөөлөгчид эрүүгийн хуулийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох (31 хувь), эрүүгийн хуульд тодорхой бус байгаа ойлголтыг тайлбарлах (29 хувь) арга хэмжээ авахыг илүү дэмжжээ. Харин прокурор, мөрдөгчдийн хувьд өмгөөлөгчидтэй адил эрүүгийн хуулийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох (28 хувь), эрүүгийн хуульд тодорхой бус байгаа ойлголтыг тайлбарлах (31 хувь) арга хэмжээ авах саналтай байна.


АСУУЛТ 13. Хуулийн этгээдэд оногдуулж буй татан буулгах, эрх хасах албадлагын арга хэмжээг ял болгон өөрчлөхийг дэмжих эсэх

График 24. Татан буулгах, эрх хасах албадлагын арга хэмжээг ял болгон өөрчлөхийг дэмжих эсэх



Судалгаанд оролцсон нийт 103 оролцогчийн хоёр хүн тутмын нэг нь буюу 54 хувь нь энэхүү саналыг дэмжихээ илэрхийлсэн бол 33 хувь нь дэмжихгүй, харин 13 хувь нь энэ санал дээр ямар байр суурь илэрхийлэхээ мэдэхгүй байна гэжээ. График 25-д албан тушаал тус бүрээр дээрх үзүүлэлтийг задлан харууллаа.

График 25. Татан буулгах, эрх хасах албадлагын арга хэмжээг ял болгон өөрчлөхийг дэмжих эсэх (албан тушаалаар)



Албан тушаалын ангиллаар харахад хуулийн этгээдэд оногдуулж буй татан буулгах, эрх хасах албадлагын арга хэмжээг ял болгон өөрчлөх саналыг албан тушаал бүрээс 52-59 хувьтай дэмжиж байна. Мөн албан тушаал бүрээс 30 орчим хувь нь энэхүү өөрчлөлтийг дэмжихгүй байгаа гэсэн бол үлдсэн хувь нь сайн мэдэхгүй байна гэжээ.


АСУУЛТ 14. Эрүүгийн хуулийн “Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан журмын дагуу хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгсөн эрх бүхий албан тушаалтныг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэсэн заалтыг хуульчид практикт хэрхэн хэрэглэж байна вэ?

График 26. Дурдсан заалтыг практикт хэрэглэж буй байдал



Судалгаанд оролцсон нийт 103 оролцогчийн саналд хамгийн өндөр буюу 34 хувь нь эрүүгийн хуулийн тухайлсан заалтыг хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхийн зэрэгцээ эрх бүхий албан тушаалтанд давхар хариуцлага хүлээлгэх байдлаар хэрэглэж байгаа гэсэн бол хамгийн бага буюу 5 хувь нь зөвхөн төлөөлөх эрх бүхий хувь хүний үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх байдлаар хэрэгжүүлж байна гэжээ.

График 27. Дурдсан заалтыг практикт хэрэглэж буй байдал
(албан тушаалаар)



АСУУЛТ 15. Цаашид Монгол Улсад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар Та саналаа бичнэ үү.

Энэхүү нээлттэй асуултын хувьд судалгаанд оролцогч өөрийн санал бодлыг бичгээр буулгасан бөгөөд өгсөн саналуудыг албан тушаал бүрээр Хүснэгт 4-т харуулав.

Хүснэгт 4. Цаашид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаарх санал (албан тушаалаар)

Шүүгч
Гадаад улсын туршлагыг судалсны үндсэн дээр материаллаг болон процессын хэм хэмжээг нэг мөр ойлгох талаар УДШ-ээс албан ёсны тайлбар гаргах
Гадаад улсын туршлагыг судлах, хуулийг төрөлжүүлэх
Гэмт хэргийн төрлийг олшруулах
Зарим төрлийн гэмт хэргийг хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр нэмэгдүүлэх (2 санал)
Их хэмжээний хохирол учруулсан хуулийн этгээд болон улс төрийн намд эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлагатай
Хуулийн этгээд гэсэн ойлголтын хүрээг тэлж, төрийн зарим байгууллага, нийтийн эрх зүйн этгээд, улс төрийн намд хариуцлага хүлээлгэдэг болох
Хуулийн этгээдээс гадна зөрчил үйлдэгчид давхар хариуцлага хүлээлгэх шаардлагатай
Хуульчдад сургалт хийж, чадварыг нь нэмэгдүүлэх
Хуульчдын дунд нэгдсэн нэг мөр ойлголт, практик тогтоох шаардлагатай
Хуульчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх
Эрүүгийн болон ЭХХШТХ-ийг илүү боловсронгуй, нэг мөр болгох

Хүснэгт 4-ийн үргэлжлэл

Эрүүгийн хариуцлагыг хувь хүнд нь, харин хохирлыг хуулийн этгээдээс гаргуулдаг байдлаар хуульчлах

ЭХ-ийн 10, 11 дүгээр бүлэгт заасан гэмт хэрэгт хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх

Өмгөөлөгч

Гадаад орнуудаас туршлага судлах (2 санал)

Гадаадын туршлагад үндэслэн судалж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хуулийн этгээдэд холбогдох тусгай хэргийг мөрдөх боловсон хүчин бэлтгэх шаардлагатай

Сургалт шаардлагатай

УДШ-ийн тайлбар хэрэгтэй байна

Эрдэмтдийг оролцуулж сайн судалгаа хийлгэж саналыг нь авах

Ялын төрлийг олшруулах

Прокурор, мөрдөгч

Байгаль орчинд учирсан хохирлын дүнг өндөр тогтоох

Бусад хууль тогтоомжоо судалж зөрчлийг арилгах

Гадаад орнуудтай харьцуулан судалгаа хийж, сургалт явуулах

Гадаад улсын туршлага судалж, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах

Мөрдөн шалгах ажиллагааны явцад хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийг нотлон шалгах, үнэлэх асуудлаар хуульчдыг сургах

Нөхөрлөлд хариуцлага тооцох

Нэг мөр ойлгох үүднээс тайлбар гаргах, хуульчдад сургалт хийх

Одоогийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хуульчдаас судалгаа авч дүгнэх

Хүснэгт 4-ийн үргэлжлэл

Практик сургалтыг нэмэгдүүлэх

УДШ-ээс хуулийг зөв хэрэглэх практик тогтоох

Хариуцлагыг хүндрүүлэх, эрх зүйн орчныг сайн бүрдүүлэх

Хуулийг боловсронгуй болгох шаардлагатай судалгаа хийх

Хуулийг нэг мөр хэрэгжүүлэх

Хуулийг улам боловсронгуй болгох, хэрэг шалган шийдвэрлэх онол-арга зүйг тогтоох

Хуулийн заалтыг илүү нарийвчлан тодорхой болгох

Хуулийн этгээд, хувь хүний үйлдлийг тодорхой хуульчилж өгөх

Хуульд маш тодорхой өөрчлөлт оруулах

Хуульчдаас санал асуулга авах, судалгаа хийж, нэгдсэн нэг мөр ойлголттой болох

Хуульчдын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх

Шийдвэрлэсэн хэрэг, практикийг судалж, хууль, эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгох

Эрүүгийн хариуцлага хүлээх субъект болох хуулийн этгээд нь маш тодорхойгүй, эзэн биегүй байгааг тодруулах

Эрх зүйн орчныг боловсронгуй болгох

ЭХХШтХ-д хуулийн этгээдийг мөрдөн шалгах ажиллагаа явуулах харилцааг тусгайлан зохицуулж өгөх

Ял оногдуулсан тухай шийдвэрийг олон нийтийн хэрэгслээр тараах

ISBN 978-9919-9812-7-3



9 789919 981273